**"Сэлэнгэ аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн тайлан**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1. НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ** | | | | | | | | | | |
| 1 | 1.1. Байгалийн унаган төрхийг хамгаалж уламжлалт ёс заншил, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэн монгол хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар авьяас билгийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ. | 1.1.1. Гэр бүлийн харилцаанд хүүхэд, залуучуудад эх орон, тусгаар тогтнолоороо бахархах, үндэсний соёл, зан заншлаа дээдлэн хүндлэх, газар нутаг, байгаль орчноо хайрлах зөв хандлагыг төлөвшүүлэх, айл өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Гэр бүлийн харилцаанд үндэсний соёл, зан заншил, удам судраа дээдлэн хүндлэх, хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эцэг эхчүүдийн үлгэр дуурайл, зөв хандлагыг дээшлүүлэх талаар зохион байгуулсан сургалт, уулзалтын тоо -Айл өрх бүр угийн бичгийг хөтлөх талаар зохион | 28 сургалтад 2500 иргэн | Эх орноо хайрлах үзэл төлөвшиж, өрх бүр угийн бичгийг хөтөлдөг болно. | | Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд монгол хүний удмын санг хамгаалах, ураг төрлөө таньж мэдэх, "Угийн бичиг хөтлөх"-ийн ач холбогдлыг сурталчилан иргэдэд мэдлэг олгох ажлыг Монголын Угийн бичгийн академийн Сэлэнгэ аймгийн Салбар зөвлөлтэй хамтран "Угийн бичгээ хөтөлж, Удмын сангаа хамгаалъя" "Үндэсний бичиг үсгийн баяр","Монгол бичгийн уран бичлэгийн бүтээлийн үзэсгэлэн", "Үндэсний бичиг үсэг өв соёлоо эрхэмлэгч байгууллага" шалгаруулах арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 2300 гаруй төрийн албан хаагчдыг хамруулж, "Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол" зөвлөгөө, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэн, "Угийн | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан арга зүйн сургалтад хамрагдсан өрхийн эзлэх хувь -Угийн бичиг хөтөлдөг өрхийн нийт өрхөд эзлэх хувь | | | | бичгээ хөтөлцгөөе” шилдэг угийн бичиг шалгаруулах уралдаан, угийн бичгийн сурталчилгааны самбарыг шинэчлэн өрх бүрийн бүртгэл судалгааг нээлттэй танилцуулан 4 удаагийн сургалт сурталчилгааг зохион байгуулж, 2023 онд угийн бичгээ сурталчилан таниулах хөтлөх аргачлалыг шилдэг өвлөн уламжлагч Л.Туултай хамтран “Угийн бичиг хөтлөх сургалт”-ыг Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн 70 сурагчдад, 145 төрийн байгууллага, иргэдийг оролцуулж, эдгээр иргэдээс 84 иргэн ургийн баяр хийсэн.<br>“Угийн бичгээ хөтөлж, ураг удмаа мэдэцгээе” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж, “Гурван цагийн хэлхээс” уралдааныг 5 төрлөөр зохион байгуулж, ”Шилдэг сум”-аар Дулаанхан тосгон, “Шилдэг баг”-аар Жавхлант сумын Бумбат баг, “Би угаа сайн мэднэ” төрлөөр Орхон сумын иргэн, “Бүтээлч угийн бичиг”-ээр Орхон сумын иргэн, “Угийн бичгийг түгээн дэлгэрүүлэгч”-ээр Монголчуудын Угийн бичгийн академийн Сэлэнгэ салбарын тэргүүн тус тус шалгарч, 48 удаагийн сургалтад 2391 албан хаагч хамруулан 1586 зөвлөмж гарын авлага тарааж, 2023 онд шинээр 30 өрх угийн бичиг | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хөтөлснөөр нийт 1577 өрх угийн бичгээ хөтөлж 167 иргэн ургийн баяр хийсэн байна. | |
| 2 | | 1.1.2. Эх оронч үзэл төлөвшүүлэхэд чиглэсэн заавал уншиж судлах түүх, соёл, урлаг, ардын аман зохиол, тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн, утга зохиолын бүтээлийн жагсаалт, ном, гарын авлага гаргаж, иргэд олон нийтэд ашиглах боломжийг хангана. | 2021 - 2025 | - | Өсвөр үе, залуучуудын заавал уншиж судлах түүх, соёл, урлаг, утга зохиолын бүтээлийн жагсаалт гаргаж, тэдгээрийг хэвлэн нийтлэх, олшруулж, судлуулсан байдлын эзлэх хувь - Суралцагсдад эх оронч хүмүүжил олгож буй сургалтын талаар багш нарт зориулсан гарын авлага - Гарын авлагаар хангагдсан өрхийн хувь - Эх оронч хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрт | Эх оронч хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрт хамрагдсан суралцагчид 20 хувиар нэмэгдэгдэнэ. | Соёлын үйлчилгээг өрх бүрт хүргэнэ. | | Заавал уншиж судлах түүх, соёл, урлаг, ардын аман зохиол, тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн, утга зохиолын бүтээлийн жагсаалтын дагуу 60 гаруй арга хэмжээг зохион байгуулсан.<br>Соёл, урлагийн байгууллагууд үндэсний соёл, урлагийг олон нийтэд сурталчилан таниулах, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, онцлог шинж чанарыг хадгалан хөгжүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, үндэсний соёлын бүтээгдэхүүн үйлчилгээ, өвийг хадгалан хамгаалах 57 арга хэмжээг 229 иргэдэд үйлчилж, соёлын үйлчилгээг өрх бүрт хүргэсэн. Соёл урлагийг 26 байгууллагаас хүүхдэд зориулсан тайзны хэлбэрт дуулалт жүжиг 5, музейн боловсролын хөтөлбөр 2, урлагийн боловсролын хөтөлбөр 3, сургалт дугуйлан 23, соёлын өв, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дадлага, сургалт 17, урлагийн их болон бага наадам 15, кино үзвэр, дэлгэцийн боловсролын арга хэмжээ давтагдсан тоогоор 289, гадаа талбайн арга хэмжээ 78, цахим уралдаан 19 удаа тус тус зохион байгуулж 17000 гаруй хүүхдийг хамруулсан. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдсан суралцагчдын эзлэх хувь | | | | 2023 онд аймгийн Нийтийн номын сан, ерөнхий боловсролын сургууль, сумдын орон нутаг судлах номын сангийн фондуудад 371 ширхэг уламжлалт тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн, утга зохиолын бүтээлийн жагсаалт, ном, гарын авлагаар баяжуулан ард иргэдэд үйлчилгээ үзүүлсэн. | |
| 3 | | 1.1.3. Эх орны үзэсгэлэнт байгаль, түүхэн газар орноор ард иргэд, хүүхэд багачуудыг тойрон аялуулах хөдөлгөөн өрнүүлж хэвшүүлэх, байгаль орчин, түүх, соёлын дурсгалын ач холбогдлыг ойлгуулж, хамгаалах ухамсар төлөвшлийг олгоход чиглүүлэн, түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах үйл ажиллагаанд | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Эх орны байгалийн үзэсгэлэнт газар нутаг, түүхэн газар орноор өсвөр үе, залуучуудын дунд зохион байгуулсан тойрон аялалын тоо - Орон нутгийн түүхэн газруудын маршруттай болсон сумдын тоо - Сэргээн засварлах үйл ажиллагаанд оролцогсдын тоо | Тойрон аялал 3 | Түүх соёлын мэдлэг сайжирч, түүх соёлын хадгалалт хамгаалалт сайжирна | | “Байгалийг ойроос” дэлхийд ховордсон хөхтөн амьтад, шувууд, Монгол орны байгалийн үзэсгэлэнт газруудын фото зураг, “Хувьсгал мандсан өглөө” уран зургийн түр үзэсгэлэн зохион байгуулж, 580 хүнд үйлчилж, соёлын биет өвүүдээс цаасан суурьтай 21 өвийг сэргээн засварлаж, судалгааны ажлыг гүйцэтгэн, дурсамж, гэрэл зургаар бүртгэл мэдээллийн санг баяжуулан түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудын маршрутыг батлуулсан.<br>“Хавцалын хадан хясаа”, “Булагтайн ам”, “Найдаг уулын хадны бичээс”, “Дэрст булангийн бичигт хад” зэрэг 150 гаруй түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудын зураг, түүхийг мэдээ баримтад түшиглэн олон нийтэд сурталчилж, “Соронзон хад-2023”, “Орон нутагтайгаа танилцъя” явган аялалуудыг Ерөнхий боловсролын 6 сургуулийн 281 сурагчийг хамруулж, хүүхэд | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | татан оролцуулна. | | | | | | | багачуудыг байгаль орчин, түүх, соёлын дурсгалын ач холбогдлыг ойлгуулж, хамгаалах ухамсар төлөвшлийн ажлыг сурталчилсан. Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны соёлын төвийн орон нутгийн ажилтнуудад чиглэл зөвлөмж өгч сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэн баримтжуулах маягтын дагуу 9 сум 4 тосгоны нийт 60 баримтат өвийг төрөл зүйлээр ангилан баримт бичиг- 8, гэрэл зураг -5, уран зураг- 5, ном хэвлэл - 2, судар -7, зоосон мөнгө- 9, тамга тэмдэг-2, видео бичлэг -2, бусад 20 үзмэрийг ялган бүртгэн баримтжуулсан.<br>Музейн үзмэрийн бүртгэлийн баримт бичгүүдийг MNS5643:2006 стандартын дагуу “Монгол партизан” баримал, “Найрамдлын туг” баримал, Д.Балдандорж зураачийн бүтээл “Д.Сүхбаатар МАН-ын хурал дээр”- уран зураг, Ч.Баярсайхан зураачийн “XIII зууны баатрууд”- уран зураг, аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 43-н жилийн түүх агуулсан хэмжил зүйн багажууд зэрэг 7 ширхэг үзмэрээр музейн сан хөмрөгийг баяжуулсан. | |
| 4 | 1.2. Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс | 1.2.1. Монголын нүүдэлчин ахуй амьдрал, | 2021 - 2025 | Улсын болон орон | Өв соёлыг таниулах арга хэмжээний тоо -Нөлөөллийн | Өв соёлыг таниулах арга хэмжээ-4 | Монголын нүүдэлчин ахуй амьдрал, зан | | “Монгол гэр барих, засварлах” сургалт, “Хөгжмийн ертөнц” үндэсний хөгжмийн зэмсгийг үзүүлэн таниулах үзэсгэлэн зэрэг | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ. | зан үйл, уламжлалыг таниулах ажлыг гэр бүл, боловсрол, соёл урлагаар дамжуулан хэрэгжүүлнэ. | | нутгийн төсөв | арга хэмжээг хэрэгжүүлэх иргэний нийгмийн байгууллагууд ын тоо | | үйл, өв соёлоо дээдэлсэн, бүтээлч, оюунлаг монгол хүнийг төлөвшүүлнэ. | | 10 гаруй арга хэмжээг зохион байгуулж, 10.0 мянган гаруй хүүхэд багачуудад Монгол ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх, Үндэс угсаагаар бахархах өв соёлыг бий болгон ажилласан. “Нүүдэлчин-2023” Дэлхийн Соёлын Фестивальд аймгаа төлөөлөн 61 өвлөн уламжлагч оролцож, өв соёл, уламжлалт идээ ундаа, язгуур урлаг, нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлс, хүн төрөлхтний соёлын биет бус өвүүдээ сурталчилан таниулж өв соёлоороо бахархах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардалаас 21.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, нүүдэлчин ахуй амьдрал, зан үйл, уламжлалыг таниулах ажлыг соёл урлагаар дамжуулан нэгдсэн удирдлагаар ханган ажилласан. | |
| 5 | | 1.2.2. Монгол ахуй, өв соёл, зан заншлыг илтгэсэн соёлын биет өвийг сэргээн засварлах, өвлөн үлдээх ажлыг олон нийтэд таниулан түгээнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Сэргээн засварласан соёлын биет өвийг тоо - Соёлын чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо -Мэдээллийн хэрэгслийн | Соёлын биет өвийг сэргээн засварласа н-42, Өв соёлыг өвлүүлэх арга хэмжээ 50 | Монгол ахуй, өв соёл, зан заншлын , олон нийт ойлголт хандлага дээшилнэ. | | “Ардын хувьсгал” сэдэвт цаасан суурьтай 700 ширхэг үзмэр, уран зураг, наамал, угсаатны зүйн, 17 түүхэн бие хүний эдлэл, хөөмөл, шигтгэмэл, даавуун суурьтай 271 он цагийн гэрч туг, дарцаг, зэр зэвсэг, бэлэгдэл таних тэмдэг, 73 ширхэг сэргээн засварлах үзмэрүүдийн судалгааг хийж бүртгэлжүүлсэн.<br>Аймгийн хэмжээнд 492 соёлын биет бус өвийг өвлөн | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зорилтот нэвтрүүлэг, хэлэлцүүлгийн эзлэх хувь | | | | уламжлагчийн дэлгэрэнгүй судалгааг авч, соёлын өвийн программд баяжилт хийж, 300 гаруй соёлын биет бус өвлөн уламжлагчдыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, шавь сургалтыг 36 удаа зохион байгуулж, монгол ахуй, өв соёл, зан заншил, соёлын биет өвийг сэргээн засварлах, өвлөн үлдээх ажлыг олон нийтэд таниулан түгээхэд 200,3 сая төгрөгийн сэргээн засварлалт хийсэн.<br>Сүм хийдэд хадгалагдаж буй баримтат өвийг бүртгэн баримтжуулж, 9 сум 4 тосгоны 60 баримтат өвийг төрөл зүйлээр ангилан 120 төрлийн баримт бичиг, гэрэл зураг, уран зураг ном хэвлэл, судар, зоосон мөнгө, тамга тэмдэг, видео бичлэг зэргээр эд материал, бусад 20 гаруй баримтыг бүртгэлжүүлсэн.<br>"Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг сумуудаас соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл, яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өвийн төрөл, өвлөн уламжлагчийн талаар түүвэр судалгааг 10 сум 2 тосгоны 7 ай савын хүрээнд 54 өвлөн уламжлагчийг хамруулан сурвалжлан, судалгаа шинжилгээ | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хийж, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан тархалтыг тогтоосон.<br>Аймгийн Нэгдсэн музейн үзмэрүүдээс соёлын биет өвийг дурсгалт зүйлийн хосгүй үнэт зэрэглэлд 13–р зууны дурсгалд хамаарах “Оньсон дөрөө”, “Хөө хуяг” 29 кг жинтэй дурсгалыг хосгүй үнэт дурсгалын шилжүүлсэн. | |
| 6 | | 1.2.3.“Монгол гэр”-ийн холбоотой ардын мэдлэгийг сургууль, цэцэрлэгээр дамжуулан хүүхэд бүрт өвлүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Монгол гэрээр хангагдсан сургууль, цэцэрлэгийн тоо -Мэдлэг олгох арга хэмжээний тоо -Монгол гэр барих, буулгах аргад суралцсан сурагчдын эзлэх хувь | "Монгол гэрээр 10 сургууль, 11 цэцэрлэг, Мэдлэг олгох арга хэмжээ-3, Монгол гэр барих, буулгах аргад суралцсан сурагчдын эзлэх 1 5 хувиар нэмнэ. | Хүүхэд багачууд монгол ёс заншлаас суралцана. | | Аймгийн хэмжээнд 38 цэцэрлэг, 30 сургууль ёс заншлын гэр өргөөтэй, шинээр Сүхбаатар сумын 4, 8 дугаар цэцэрлэг, Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгүүдэд орон нутгийн төсвийн 27.5 сая төгрөгийн хөрөнгөөр “Гэр өргөө”-г ашиглалтад оруулж, нийт суралцагчдын 20 хувь нь монгол гэр барих, буулгах аргад суралцаж, нүүдэлчин өв соёлыг хадгалж, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх сургалтын үйл ажиллагааг явуулах боломжтой болж, хүүхэд багачууд монгол ёс заншлаас суралцах боломж бүрдсэн.<br>Бага боловсрол буюу 1-5 дугаар ангид Монгол ёс хүмүүжил хичээл 7 хоногт 2 цагаар, 6-12 дугаар ангид иргэний ёс зүйн боловсрол хичээлийн заавал судлах 17 цагийн агуулгаар | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | дамжуулан суралцагчдад нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцах, төлөвших, хувь хүний ур чадвар олгох арга хэмжээг сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлсэн. | |
| 7 | | 1.2.4. Орон нутагт амьдардаг үндэстэн, ястны өвөрмөц ёс заншлыг судлан, түгээн дэлгэрүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Судалсан бүтээлийн тоо - Мэдээллийн хэрэгслийн зорилтот нэвтрүүлэгийн тоо/цахим/ - Соёлын биет бус өвийг сурталчилсан байгууллагын тоо -Үндэсний агуулгатай шинэ уран бүтээлийн эзлэх хувь - Сургалт явуулсан тоо Орон нутгийн соёлын өвийн онцлогийг тодорхойлно. | Судалсан бүтээл-1 Зорилтот цахим нэвтрүүлэг-1 | Орон нутгийн соёлын өвийн онцлогийг тодорхойлно. | | Аймгийн хэмжээнд амьдардаг үндэстэн ястны өвөрмөц ёс заншлыг түгээх ажлын хүрээнд сум, орон нутгийн онцлогийг харуулсан “Сэлэнгэ соёл”, “Хаврын өнгө” соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн, Казак түмний “Наурызын баяр”, “Цагаан эсгий”-ний баяр, “Өргөн Сэлэнгэ” амьд хөгжмийн наадам, “Хотон үндэсний өв соёл”, “Бид-Сэлэнгийн үр сад” урлагийн их наадам, “Эв модны наадам” эвент арга хэмжээ, “Ээж модны тахилга-Ханш нээх арга хэмжээ”, Сайхны Хөтөл, Алтанбулаг, Тужийн нарс, Соронзон хад, дуут хадны аялал жуулчлал, Амарбаясгалант хийд-Гонгорын бумбаны тахилга, “Алтаргана” урлагийн наадам зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. | 90 |
| 8 | | 1.2.5. Соёлын өвд суурилсан орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлж | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Зохион байгуулсан арга хэмжээ, уралдаан, наадмын тоо - Түүнд | Зохион байгуулсан арга хэмжээ, уралдаан, наадам-100 | Соёл, урлагийн эдийн засгийн эргэлтэд оруулна | | “Цагаан эсгийний баяр” эвент арга хэмжээ, “Өргөн Сэлэнгэ” амьд хөгжмийн наадам, “Нүүдэлчин-2023” Дэлхийн Соёлын Фестивалын анхан шатны шалгаруулалт, "Би Монгол хүн" | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эвент, арга хэмжээг тогтмолжуулан соёлын үйлчилгээг эдийн засгийн эргэлтэнд оруулна. | | | хамрагсдын тоо -Соёлын аялал жуулчлалын өсөлтийн хувь | | | | цахим уралдаан, "Миний мэдэх өв соёл" гар зургийн уралдаан, "Тоглоом наадгайг хэрхэн сайн хийх вэ?" уралдаануудыг зохион байгуулж, 2200 гаруй оролцогчийг хамруулж, соёл урлагийг эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Давхардсан тоогоор 27900 гаруй аялагч жуулчид үзэж сонирхсон. | |
| 9 | | 1.2.6. Баримтат өвүүдийг бүртгэн, олон нийтэд таниулан сурталчилна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Сан хөмрөгийн баяжилтын хувь -Бүртгэл мэдээллийн санг цахимд бүрэн хадгалсан хувь -Соёлын биет өвийг сурталчлахад хамрагдсан байгууллагын тоо, -Түүнд хамрагсдын тоо | Сан хөмрөгийн баяжилт - 2% Соёлын биет бус өвийг сурталчилсан байгууллага 1 | Олон нийтийн баримтат өвийг талаарх мэдлэг дээшилнэ. | | Сайхан сумын "Нарны охид" уран нугаралтын хамтлагийн тоглолтыг аймгийн Соёл урлагийн газрын “Өв соёлын өргөө”-нд зохион байгуулж, соёлын биет бус өв тээгч болох уран нугаралтын үзүүлбэр “Шүдэн дээр тогтох” дэлхийн рекордыг 5 минутаар эвдсэн нугараачийн бичлэгийг бүртгэл мэдээллийн цахим санд хадгалж, “Нүүдэлчин Монгол”- дэлхийн соёлын фестиваль, “Соёлын сэргэлт-2023” аян, “Соёлын бүтээлч сар”, “Сэлэнгэ соёл”, “Хаврын өнгө” арга хэмжээнд 30 гаруй соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулж, үйл ажиллагааг сурталчилан олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр олон нийтэд түгээн сурталчилж ажилласан. | 90 |
| 10 | 1.3. Үндэсний Монгол хэл, | 1.3.1. Монгол бичгийн хэрэглээний | 2021 - 2025 | Улсын болон орон | -Үндэсний бичиг үсэг сурсан | Үндэсний бичиг үсэг сурсан | Үндэсний бичгийн хэрэглээний | | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бичгээ нийтээр сурч эзэмшин, түгээн дэлгэрүүлнэ. | орчныг бүрдүүлж, хүүхэд багачууд, иргэдэд эзэмшүүлэн, "Үндэсний бичгээрээ уншиж, бичицгээе "2021-2025" аяныг өрнүүлж, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3"-ыг хэрэгжүүлнэ. | | нутгийн төсөв | суралцагчдын эзлэх хувь - Монгол бичгээр сургалт явуулах түвшинд хүрсэн багшийн хангалтын хувь -Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн шалгалтын улсын дундажаас ахисан хувь | суралцагчдын эзлэх хувь-63.4 | орчин бүрдэж, үндэсний бичгийн мэдлэг, чадвартай иргэдийн тоо нэмэгдэнэ. | | дээдлэх үзлийг хойч үедээ өвлүүлэх үүднээс жил бүрийн 05 дугаар сарын эхний 7 хоногт "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын арга хэмжээг зохион байгуулж хэвшсэн.<br>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх, 2025 оноос төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан бичгээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд "Үндэсний бичигтэн 2022-2024" хөдөлгөөн" арга хэмжээг зохион байгуулж, байгууллага бүрт үндэсний бичгээ эрхэмлэн дээдлэх, сурч судлах ажлыг өрнүүлэхийг уриалан ажиллаж байна.<br>Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг стандартын дагуу хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангаан, хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс гаргасан стандартыг байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлж ажиллаж аймгийн Засаг даргын Тамгын газрын 90 гаруй албан хаагч үндэсний Монгол бичгийн хичээлийг судлан албан хэрэгцээнд ашиглахаар бэлтгэл ажил хангаад байна. Аймгийн хэмжээний Ерөнхий боловсролын сургуулиудын бага боловсролын 92.7 хувь, суурь боловсролын 96.1 хувь, бүрэн дунд 97.9 хувь нь Монгол бичгийн | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хичээлийг боловсролын сургалтын агуулгад тусгагдсны дагуу судалж байна. | |
| 11 | | 1.3.2. Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирил болон үндэсний бичгээр хослуулан явуулах бэлтгэл ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулдаг байгууллагын тоо -Үндэсний бичгээр уншиж, бичиж чаддаг болсон төрийн албан хаагчийн тоо | Үндэсний бичгээр уншиж, бичиж чаддаг болсон төрийн албан хаагчийг 5% ахиулах | Бодлогын баримт бичиг хэрэгжинэ | | Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” /MNS 6395:2022/, төрийн албан хаагчийн нэрийн хуудсанд тавих ерөнхий шаардлага /MNS 6978:2022/-уудын талаарх мэдээллийг төрийн байгууллагуудад хүргүүлэн албан бичиг, тушаалыг кирил, монгол бичгээр зэрэгцүүлэн бичих, төрийн албан хаагчдад монгол бичгийн хичээлийг түвшинд ангилан заах ажлыг Ерөнхий боловсролын сургуулийн багш нартай хамтран хэрэгжүүлж байна. 3177 төрийн албан хаагч дундаас дээш мэдлэгтэй, үндэсний бичгээр уншиж бичиж сурсан байна. | 100 |
| **2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | | | | |
| 12 | 2.1. Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ. | 2.1.1. Сургуулийн өмнөх боловсролд 3-5 хүртэлх насны хүүхдийг бүрэн хамруулан, гэр бүлийн гишүүний ажил хөдөлмөр эрхлэх | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь -Хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдсан иргэдийн тоо | Хамран сургалт 82.5 хувьиай байна. | Хүүхэд бүр эрүүл, аюулгүй орчинд суралцах боломж бүрдэнэ. | | Дэлхий нийтийг хамарсан "Ковид-19" цар тахлын улмаас 2 настай хүүхдийг танхимын сургалтад хамруулах боломжгүй байсан бөгөөд 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 2 настай хүүхдүүдийг цэцэрлэгийн танхимын сургалтад хамруулснаар 2-5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2021 онд 83 хувь, 2022 онд 84.4 хувь, 2023 онд сургуулийн өмнөх боловсролын | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боломжийг бүрдүүлнэ. | | | | | | хамран сургалтын хувь 85.2 хувь байгаа нь хүүхэд бүр эрүүл аюулгүй орчинд сурч хүмүүжих боломжийг бүрдүүлсэн. | |
| 13 | | 2.1.2. Судалгаа арга зүйн байгууллагууд тай хамтран ажиллаж, сургууль, цэцэрлэгийн сургалтын чанарыг сайжруулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Бага, суурь, бүрэн дунд боловсролын шалгуурт суурилсан шалгалт, хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэлийн хувь - Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж онооны өсөлт, бууралтын хувь | • Бага-57.5% • Суурь-40.4% • Бүрэн дунд-41,3% ЭЕШ-503 | Сургалтын чанар, үр дүн дээшилнэ. | | 2023-2024 оны хичээлийн жилд “PISA” олон улсын үнэлгээнд 15 настай 9-11 дүгээр ангийн 192 сурагч хамруулж, Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 4, 6, Шаамар, Баянгол, Бугант, Мандал сумын 2, Билиг ДБ 7 дугаар сургуулиуд тус тус сонгогдож, Боловсрол шинжлэх ухааны яамны судалгааны үр дүнд математикийн үзүүлэлтээр дэлхийн түвшинд Сүхбаатар сумын 4 дүгээр сургууль, Мандал сумын 3, 4 дүгээр сургууль байгалийн ухааны хичээлээр ахицсан түвшинд үнэлэгдсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлж, урамшуулал олгох зорилгоор бүхий гүйцэтгэлийн үнэлгээг Боловсролын үнэлгээний төвөөс өгсөн чиглэл, удирдамжийн дагуу зохион байгуулж, Сургуулийн өмнөх боловсролын 39 цэцэрлэгийн 244 багш, ерөнхий боловсролын 35 сургуулийн 978 багш гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдлаа. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 158, Ерөнхий боловсролын сургуулийн 527 багш урамшуулалд | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хамрагдсан бөгөөд өмнөх хичээлийн жилээс 4,2-21,7 хувиар, байгууллагын үнэлгээгээр Сургуулийн өмнөх боловсролын-18, Ерөнхий боловсролын сургуулийн -25 байгууллага урамшуулал авсан ба өмнөх хичээлийн жилээс 0,8-6,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж 497 оноогоор шалгуулсан. | |
| 14 | | 2.1.3. Багш нарт мэргэжлээрээ бие дааж, тасралтгүй хөгжих боломжийг олгох, шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Чадварлаг багш” арга хэмжээг зохион байгуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Багшийн мэргэжлийг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлсэн сургууль цэцэрлэгийн эзлэх хувь -Мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн багшийн тоо -Ментор багшийн эзлэх хувь -Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй, тэргүүн туршлага түгээсэн багш нарын эзлэх хувь -Сургалтын шинэ арга зүй, | Мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалтууда д 703, цахим сургалтад давхардсан тоогоор 4269 багш хамрагдсан. | Багш нарын ур чадвар, ажлын гүйцэтгэлд ахиц гарна. | | Цахим платформд суурилуулсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих модуль сургалтыг “Aplus платформ”-оор зохион байгуулж, “Багшийн мэргэшлийн хөгжлийг дэмжих, Сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий боловсролын сургуулийн 14 судлагдахууны хөтөлбөрийн модуль-83,” “Удирдах ажилтны хөгжлийг дэмжих сургалтын модуль-7”, “Багш, ажилтны мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг дэмжих сургалтын модуль 20” сэдвээр давхардсан тоогоор Сургуулийн өмнөх боловсролын 301, Ерөнхий боловсролын 1134 багш сонгон сургалтад хамрагдсан.<br>2023 оны Боловсрол шинжлэх ухааны яамны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр ерөнхий боловсролын 527 багш хангалттай | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | технологи нэвтрүүлсэн багшийн эзлэх хувь | | | | түвшинд үнэлэгдэж, урамшуулал авсан. “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд бага боловсролд хэрэглэгдэх хэрэглэгдэхүүнийг цахимжуулж, хэвлэн нийтлэх эрх авсан QR кодоор ном унших арга барилд суралцаж амжилт гаргасан Сайхан сумын 2 дугаар сургуулийн бага боловсролын багш нарын сургалтын үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 1,5,10 дахь жилдээ ажиллаж байгаа багшийн үндсэн сургалтад 180 багш, ажилтан, орон нутгийн төрөлжсөн сургалтад давхардсан тоогоор 3500 гаруй багшийг хамруулсан. Онцгой амжилт гаргаж, аймгийн боловсролын салбарт манлайлан ажилласан Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Б.Отгонжаргал, Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш Т.Насанхүү, Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн бага ангийн багш нарыг “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд шагнан урамшуулсан. | |
| 15 | | 2.1.4. Цахим технологийг ашиглан хүн бүр суралцах, | 2021 - 2025 | Улсын болон орон | Цахим сургалт явуулах боломжтой сургууль, | Цахим сургалт явуулах боломжтой | Цаг хугацаа, зардал хэмнэх, мэдээллийг | | Багшийн үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж, сургалтын платформын хөгжүүлэлт 70 хувьтай байна. | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ. | | нутгийн төсөв | цэцэрлэгийн тоо -Онлайн сургалтад хамрагдсан сурагч, иргэдийн тоо | танхим-3, Цахим сургалтын сүлжээний орчин бүрдүүлсэн сургууль, цэцэрлэг-50, Онлайн сургалтад хамрагдсан сурагч, иргэд-1000 | түргэн шуурхай авах боломжтой болно | | Ерөнхий боловсролын сургуулийн 85,7 хувь, цэцэрлэгийн 70.9 хувь нь өндөр хурдны интернэтэд холбогдож, цахим сургуулийн сонгон судлах хичээлд 10 дугаар ангийн сурагчид хамруулж, "Medle.mn"-д ахлах ангийн 8 судлагдахууны 68 цахим контент оруулснаас 27 ээлжит хичээл батлагдан 41 ээлжит хичээлийн цахим сангийн боловсруулалт хийгдсэн.<br>Ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх, дэвших шалгалтыг зохион байгуулж, суурь боловсролын төгсөх 8, дэвших ангийн 13 судлагдахуунаар даалгаврын санг бүрдүүлэн шалгалтуудыг зохион байгуулсан.<br>Улсын төсвөөс 1396,6 сая төгрөгийн санхүүжилтаар багшийн хөгжил, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах, цахим ангийг байгуулахаар сургалтын 15 ширхэг суурин компьютер, 15 ширхэг зөөврийн компьютер-15 ширхэг, сургалтын таблет 943 ширхэг, 9 ширхэг ухаалаг дэлгэц самбарыг нийлүүлж 35 сургуулийн багш нарыг цахимаар сургалт явуулах боломжийг хангаж 5000 мянган сурагч, 27000 иргэнийг цахим сургалтад хамруулсан.<br>Бүгд Найрамдах Солонгос Улсын Жэжү аймгийн Боловсролын газраас Мандал сумын Ерөнхий | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | боловсролын 3 дугаар сургуульд 260.0 сая төгрөгийн мэдээлэл зүйн кабинетийн иж бүрэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлж, цахим технологийг ашиглан хүн бүр суралцах боломжийг бүрдүүлсэн.<br>2023 онд нийт 13 ерөнхий боловсролын сургуулиудын 1127 багш, сургуулийн өмнөх боловсролын 301 багш нар “Цахим технологи ашиглах модуль сургалт”-д хамруулахад 268.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, “Багш хөгжлийн төв”-ийг байгуулж, иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан. | |
| 16 | | 2.1.5. “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Техник, тоног төхөөрөмжийг шинэчилсэн сургууль, цэцэрлэгийин эзлэх хувь -тоглоом наадгай, ном, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан цэцэрлэгийин эзлэх хувь | Техник, тоног төхөөрөмжийг шинэчилсэн сургууль-70, цэцэрлэг-80 | Сургалтын орчин сайжирч, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. | | “Сургалтын байгууллага - тоног төхөөрөмж” арга хэмжээг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны зардал болон төсвийн хөрөнгө оруулалтаас Ерөнхий боловсролын сургуулийн 6 сургуульд 54,0 сая төгрөгийн физикийн хичээлийн тоног төхөөрөмж, Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн гадна талбайн тохижилтод 60,6 сая төгрөг, тус сумын 1, 6 дугаар цэцэрлэгт 11,4 сая төгрөг, 1 дүгээр сургуульд 53,2 сая.төгрөгийн орос хэлний лингафоны кабинет, хөгжим хэрэгсэл, Мандал сумын 1 дүгээр сургуульд 6,4 сая төгрөгийн хөгжим, техник хэрэгсэл, Сант сумын цэцэрлэгт 6,9 сая төгрөгийн | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | гал тогооны тоног төхөөрөмжийг тус тус нийлүүлж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж ажилласан.<br>“Багш хөгжлийн төв”-ийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, сургуулийн өмнөх боловсролын 39 цэцэрлэгт 46,7 сая төгрөг, ерөнхий боловсролын 35 сургуульд 303,0, сая төгрөгийг мэдээлэл технологийн тоног төхөөрөмжөөр хангаж, багш нарын мэргэжил дээшлүүлэхэд Ерөнхий боловсрол сургуульд 299,0 сая төгрөг, цэцэрлэгт 74,9 сая төгрөг, Зүүнбүрэн сумын цэцэрлэгийн багш хөгжлийн төвд 58,0 сая төгрөг, Зүүнбүрэн, Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн англи хэлний лингафоны танхим байгуулахад 47,0 сая төгрөг, Оросын холбооны улсын Элчин сайдын яамны дэмжлэгээр орос хэлний лингафоны танхимыг байгуулсан.<br>Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн “Багш хөгжлийн төв”-д 157,0 сая төгрөгөөр иж бүрэн зөөврийн компьютер, тоног төхөөрөмж, тавилгын хөрөнгийг шийдвэрлэж дэмжлэг үзүүлсэн. | |
| 17 | | 2.1.6. Хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн илрүүлж, дэмжлэг | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Дугуйлан, секц, клубт хамрагдсан суралцагсдын тоо; -Амжилт | Дугуйлан, секц, клубт хамрагдсан суралцагсдын тоо- | Хүүхэд бүр авьяас, чадвараа хөгжүүлж, чөлөөт цагаа | | Аймгийн ерөнхий боловсролын 35 сургуулийн 109 байгууллагын 500 нэр төрлийн дугуйлан клуб, секцэнд давхардсан тоогоор 19,0 мянган гаруй суралцагчдыг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үзүүлэн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх “Хүүхэд хөгжлийн ордон” барина. | | | үзүүлсэн хүүхдийн эзлэх хувь -Номыг бүтээлчээр унших арга зүйг эзэмшсэн суралцагчийн тоо | 9520, Амжилт үзүүлсэн хүүхдийн эзлэх хувь-15 -Номыг бүтээлчээр унших арга зүйг эзэмшсэн суралцагчийн тоо-375 | зөв өнгөрүүлнэ. | | хамруулж, үүнээс амжилт гаргасан 219 хүүхдийг шагнаж, урамшуулсан.<br>Ерөнхий боловсролын сургуулиудад 505 багш, 14 иргэн гэрээгээр ажиллаж, сургуулийн орчинд хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байна.<br>Улсын төсвийн 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 дүгээр багт баригдаж буй “Хүүхэд хамгаалал, хөгжлийн төв”-ийн барилгын гүйцэтгэгчээр “Бүрэн одод” ХХК шалгарч, 90 хувийн гүйцэтгэлтэй 2024 оны 04 дүгээр сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | |
| 18 | | 2.1.7. Сургуулиудад “Хөдөлмөр амралтын зуслан” байгуулж, түүнийг түшиглэн сургууль, цэцэрлэгүүдэд аж ахуй эрхлэх боломжийг нь бүрдүүлнэ. | 2021 - 2025 | Улсын төсөв, орон нутгийн төсөв, хандив тусламж | -Туслах аж ахуйтай болсон сургууль, цэцэрлэгийн эзлэх хувь -Зуслангийн ерөнхий шаардлага хангасан хөдөлмөр амралтын зуслангийн тоо -Түүнд хамрагсдын тоо | Туслах аж ахуйтай болсон сургууль, цэцэрлэгийн эзлэх хувь-5 -Зуслангийн ерөнхий шаардлага хангасан хөдөлмөр амралтын зуслангийн тоо-1 -Түүнд хамрагсдын тоо-200 | Сурагчдын зуны амралтыг үр дүнтэй өнгөрүүлэх, эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах боломж бүрдэнэ. | | Аймгийн хөрөнгө оруулалтаар Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн 1 ээлжиндээ 25-30 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай хөдөлмөр амралтын зуслан байгуулж ашиглатад оруулсан.<br>Аймгийн хэмжээнд 32 сургууль, 40 цэцэрлэг туршилтын болон ногооны талбай, хүлэмжид 706 кг помидор, 1399 кг өргөст хэмх, 175 кг салат навч, 357 кг амтат чинжүү, 30331 кг төмс, 33501 кг лууван, 1447 кг манжин, 730 кг сонгино, 2366 кг байцаа, 115 кг сармис нийт 71127 кг хүнсний ногоо хураан авч, жимс, ногооны туслах аж ахуй | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эрхлэх боломжийг бүрдүүлсэн. Алтанбулаг, Сант, сумын сургууль 1-5 га талбайн газрыг гэрчилгээжүүлэн хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарьсан.<br>Хөдөлмөр амралтын зуслан хүүхэд багачууд хүнсний ногоо жимс жимсгэнэ тарьж ургуулах, арчилах, хамгаалах болон чөлөөт цагаараа танин мэдэхүйн, урлаг спортын тэмцээн уралдаан зохион байгуулж суралцах, хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж байна. | |
| 19 | | 2.1.8. Сургалтын бүх байгууллагын ариун цэврийн байгууламжийг сайжруулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, хандив, тусламж | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай сургууль, цэцэрлэгийн эзлэх хувь | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай сургууль-85.7 цэцэрлэгийн эзлэх хувь-100 | 8 сургууль, 1 дотуур байрыг дотор ариун цэврийн байгууламжтай болгож, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн байна. | | 2023 онд сургуулийн 85,7 хувь, дотуур байр, цэцэрлэг 100 хувь ариун цэврийн дотор байгууламжаар үйлчлүүлж байгаа бөгөөд цаашид нөхцөлийг сайжруулах, стандартад нийцүүлэхээр ажиллаж байна.Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төслийн хүрээнд 10 сумын сургуулийн хичээлийн 12 байр, 5 дотуур байр, 4 цэцэрлэг нийт 21 обьект сонгогдсон.I, II ээлжид Баруунбүрэн, Цагааннуур 2 сумын сургууль, цэцэрлэгийн дотуур байр 6 обьектод ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангахуйцаар сайжруулах ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, үүрэг даалгаврын биелэлтээр | 90 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ашиглалтад авсан.III ээлжид Алтанбулаг сумын сургуулийн хичээлийн 2-р байр, цэцэрлэг, Баянгол сумын сургуулийн хичээлийн байр, Зүүнбүрэн сумын сургуулийн хичээлийн байр, дотуур байр, цэцэрлэг, Хушаат сумын сургуулийн хичээлийн байр, дотуур байр, цэцэрлэг зэрэг 4 сумын 9 обьектод зураг төсөв, магадлал хийгдэж, барилга угсралтын тендер зарлагдан үйл ажиллагаа эхлээд байна. IV ээлжид Түшиг сумын хичээлийн байр, дотуур байр, Ерөө сумын Бугант тосгоны сургуулийн хичээлийн байр, Мандал сумын 1-р сургуулийн хичээлийн байр, Мандал сумын Тарни багийн сургуулийн хичээлийн байр, Орхонтуул сумын Рашаант тосгоны сургуулийн хичээлийн байр зэрэг 4 сумын 6 обьектийн зураг, төсвийн ажил үргэлжилж байна.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд сургалтын орчны стандартын шаардлага хангасан дотор ариун цэврийн байгууламжтай.Багш, ажилтнууд болон сурагчдын гар угаах угаалтуурыг 35 сургууль, 43 цэцэрлэг нийтдээ 62.0 сая төгрөг зарцуулан сайжруулан, шинэчилсэн бөгөөд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, иргэдийн | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | оролцоо, санаачилгыг дэмжин ажилласан байна. 2023 онд сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн орчин нөхцөлийг сайжруулж, 295.7 сая төгрөгийн зардлын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн. | |
| 20 | | 2.1.9. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны сургалтын таатай орчинг бүрдүүлэх, хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлыг стандартад нийцүүлэх ажлыг ээлж дараатай шийдвэрлэнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, хандив, туслам ж | Стандартын шаардлага бүрэн хангасан бүх шатны сургалтын байгууллагын эзлэх хувь | Стандартын шаардлага бүрэн хангасан бүх шатны сургалтын байгууллагы н эзлэх хувь-65 | Сургалтын таатай орчин бүрдэж, хүүхэд бүр сурч, хөгжих боломж бүрдэнэ. | | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 60 дугаар тогтоолоор батлагдсан “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын 16 сургууль, дотуур байранд 33 ширхэг 98.5 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.<br>Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолонд 12 нэр төрлийн 77 ширхэг тоног төхөөрөмж, дотуур байрны гал тогоонд 8 төрлийн 26 ш тоног төхөөрөмж, цэцэрлэгт 12 нэр төрлийн 85 ш тоног төхөөрөмж, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад 8 нэр төрлийн 10 ш тоног төхөөрөмж, нийт 198 ш 537,1 сая өртөг бүхий гал тогооны тоног төхөөрөмж шаардлагатай байгаа бөгөөд холбогдох газруудад уламжилж, Сант сумын цэцэрлэгт 6,9 сая төгрөгийн өртөг бүхий гал тогооны тоног төхөөрөмж, Сүхбаатар сумын 1,3,8 дугаар цэцэрлэгийн “Дезерет” Олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар иж бүрэн гал тогооны | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | тоног төхөөрөмжөөр хангасан.Нийт 35 сургууль, 43 цэцэрлэгийн 65 хувь нь мэргэжлийн тогооч ажиллаж ажил үйлчилгээ үзүүлж байна. | |
| 21 | | 2.1.10. Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллежийг дэмжиж, орон нутгийн онцлог давуу талд түшиглэн, мэргэжлийн төрлийг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Төгссөний дараа мэргэжлээрээ ажил эрхэлж буй МСҮТ төгсөгчдийн эзлэх хувь -- Мэргэжлийн ангийг төрөл нэмэгдүүлсэн тоо | Төгссөний дараа мэргэжлээрээ ажил эрхэлж буй МСҮТ төгсөгчдийн эзлэх хувь-75% - Мэргэжлийн ангийг төрөл нэмэгдүүлсэн тоо 13 | Ур чадвартай мэргэжлийн боловсон хүчнээр хангагдах боломж бүрдэнэ. | | Боловсролын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолоор Шаамар сумын МСҮТ-үүдийг Сүхбаатар сумын Мэргэжил сургалт үйлдвэрийн төвийг нэгтгэн Сэлэнгэ аймаг дахь Хөдөө аж ахуй их сургуулийн харьяа Политехникийн коллеж болгож сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг ажиллаж сургалтын үйл ажиллагаа идэвхижүүлэн ажиллаж байна.<br>Зүүнхараа Политехник коллеж нь орон нутгийн онцлог давуу талдаа түшиглэн мэргэжлийн төрлөө нэмэгдүүлэхээр Хөдөө аж, ахуйн мэргэжлээр төрөлжүүлэн хөгжүүлэх байгууллагын урт хугацааны төлөвлөлтийн хүрээнд "Ойн техникч" мэргэжлийн анги нээж, энэ хичээлийн жилд 2-р курст 17 суралцагч хамрагдаж байна. 2023-2024 оны хичээлийн жилийн эхний элсэлт: нийт 409 ·мэргэжлийн боловсролын 1 жил - 284 · мэргэжлийн боловсролын 3 жил – 134 2023 онд төгссөн: Зүүнхараа Политехник коллеж | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2023 оны 1 сард - 52, 6 сард - 87, нийт 139 төгссөн ба хөдөлмөр эрхлэлт 66,4% Сэлэнгэ Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв: 2023 оны 1 сард - 34, нийт 95 төгссөн ба хөдөлмөр эрхлэлт 72.40% Шаамар Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв: нийт 113 төгсөгчөөс хөдөлмөр эрхлэлт 48% байгаа нь нийт хөдөлмөр эрхлэлтийн дундаж 62.3%-тай байна. | |
| 22 | 2.2. Эрүүл мэндийн бодлогыг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ. | 2.2.1. Иргэн бүрт эрүүл мэндийн боловсролыг олгож, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулах ажлыг тасралтгүй зохион байгуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын тоо -Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүүхэд, иргэдийн хамрагдалтын хувь -Шинжилгээнд хамрагдсан иргэд хүүхдийн хувь | Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын тоо-16 -Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүүхэд, иргэдийн хамрагдалтын хувь75 -Шинжилгээнд хамрагдсан иргэд, хүүхдийн хувь 20 | Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж ,чанар сайжирна. | | Хүн амын нас хүйс, эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээ”-ний 6 багц үзлэгийг анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагуудад аймгийн хэмжээний 107.8 мянган иргэнд үйлчилгээг үзүүлэхээр аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийг дэмжих төвийг 2022 онд байгуулсан.<br>Аймгийн хэмжээнд хамрагдалт 31 хувь, хүүхдийн 0-17 насны 2 багц үзлэг, оношилгоонд 37981 хүүхэд хамруулахаас 25507 хүүхэд хамруулж, хамралт 67,2 хувьтай байна. Насанд хүрэгчийн 4 багцын 69918 иргэн хамруулахаас 8917 насанд хүрсэн иргэн хамруулж, хамралт 12,7 хувь байна.<br>17 сум 6 тосгоны “Мэдээлэл түгээгч” сайн дурын бүлгийг байгуулж, иргэдийг шинэ төрлийн | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, тэднийг мэдээллээр хангах зорилтын хүрээнд 125 төрлийн мэдээллийг орон нутгийн цахим хуудсаар 2596 удаа түгээж, 35263 иргэдийн хандалтыг авсан байна. | |
| 23 | | 2.2.2.Өсвөр насныхны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл аж төрөх арга барилд суралцуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Үзлэгт хамрагдсан өсвөр насны хүүхдийн тоо - Зохион байгуулагдсан сургалтын тоо - Эрүүл мэндийн сургалтад хамрагдах суралцагчдын тоо -Эрүүл суралцагчдын тоо | "Үзлэгт хамрагдсан өсвөр насны хүүхдийн тоо 460 - Зохион байгуулагдсан сургалтын тоо-8 -Эрүүл мэндийн сургалтад хамрагдах суралцагчдын тоо 484 - Эрүүл суралцагчдын тоо 1500 | Өсвөр насныханд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирна. | | Өсвөр үеийнхэнд “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх" кабинеттай анхны аймаг боллоо. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөрийн санхүүжилтээр “Өсвөр үеийнхэнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх" кабинет шинээр байгууллаа. Тус кабинетаар дамжуулж өсвөр үеийнхэнд нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан сэдвээр лекц, сургалт явуулах мөн эрүүл, зөв дадал хэвшилд сургахаас гадна ахлах болон төгсөх ангийн 60 гаруй сурагчдад арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн өсвөр үеийн кабинетаар 1985 хүүхэд үзлэгт хамрагдаж, аймгийн хэмжээнд 0-17 хүртэлх насны хүүхдийн эрт илрүүлгийн үзлэгт 25507 хүүхдийг хамруулсан.“Осол гэмтлээс сэргийлэх”, “Илүүдэл жин, таргалалтыг бууруулах”, “Эрүүл зөв хооллолт”, Бэлгийн | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | замаар дамжих халдварт өвчин”, “Эрүүл амьдралын хэв маяг”, Өсвөр нас ба шилжилтийн нас”, “Өсвөр насны сэтгэл зүйн онцлог”, “Амны хөндийн өвчлөл”, “Архи тамхины хэрэглээ” сэдэвт 56 удаагийн сургалт, нөлөөллийн ажилд өсвөр насны 3689 хүүхдийг хамруулсан. | |
| 24 | | 2.2.3. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах бэлэн байдал, нөөц бүрдүүлэлт, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, -Түүнд хамрагсдын тоо -Бэлэн байдлын төлөвлөгөөтэй болсон байгууллагын тоо -Цахимаар арга хэмжээг зохион байгуулах боломжтой байгууллагын тоо | Зохион байгуулсан арга хэмжээний тоо-10 -Түүнд хамрагсдын тоо-2800 -Бэлэн байдлын төлөвлөгөөтэй болсон байгууллагын тоо 10 -Цахимаар арга хэмжээг зохион байгуулах боломжтой байгууллагын тоо-100 | Бэлэн байдал хангагдана. | | “Ковид-19" халдварт цар тахлын үед хэрэглэх 38 төрлийн 86,853 эм, 16 төрлийн 182,178 хувийн хамгаалах хэрэгсэл, 12 төрлийн 81,657 эмнэлгийн хэрэгслийн 14-30 хоногийн нөөцийг бүрдүүлж, Баянгол, Сайхан, Ерөө сумын Эрүүл мэндийн төвүүдэд нийт 25.8 сая төгрөгийн уушгины багтаамж шалгах спирометр багаж болон дагалдах хэрэгсэл, ковидын дархлаажуулалт, вакцины хэмийн хяналтыг системийг сайжруулахад 11.2 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмж нийлүүлж бэлэн байдлыг хангаn ажилсан.<br>Эрүүл мэндийн байгууллагуудад ариутгал халдваргүйтгэлийн бодисын 21285 кг нөөцийг бүрдүүлсэн. | 100 |
| 25 | | 2.2.4. Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санд тулгуурлан | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Эрүүл мэндийн үйлчилгээний төрлийн тоо -Мэдээллийн цахим сангийн | Эрүүл мэндийн үйлчилгээний төрлийн тоо 25 - | Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ | | “Цахим эрүүл мэнд” төслийг хэрэгжүүлж, Сэлэнгэ, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг “E-Health” программыг нэвтрүүлж, амбулаторийн цахим бүртгэл, | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цахим сүлжээг нэвтрүүлж, иргэдийн өдөр тутмын оношилгоо, эмчилгээ, сувилгаа, сэргээн засах үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай үзүүлнэ. | | | баяжилтийн хувь -Цахим сүлжээний орчин бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | Мэдээллийн цахим сангийн баяжилтийн хувь 100 - Цахим сүлжээний орчин бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь 100 | шуурхай болно. | | үзлэгийн кабинет, тасгууд, лаборатори хоорондоо цахимаар холбогдон оношилгоо, үзлэгийн дугаар авах, шинжилгээнд илгээх, хариу авах, яаралтай тусламжийг эрэмбэлэн цаг алдалгүй оношилгоо шинжилгээнд илгээх, хариуг хүргэх зэрэг 28 төрлийн эрүүл мэндийн үйлчилгээг шуурхай үзүүлсэн. 2023 онд www.e-mongolia.mn болон иргэдэд үйлчлэх тусгай дугаараар 4406 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах цаг олгож эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд e-hospital программыг 2022 оны 8 дугаар сараас нэвтрүүлэн давхардсан тоогоор 1.2 сая удаагийн үзлэг хийж 6500 иргэдийг хэвтүүлэн эмчилсэн. | |
| 26 | | 2.2.5. Өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн ортой болон үүдэн эмнэлэг, эмийн сан, сувилал, сувилахуйн төв, ариутгал халдваргүйтгэл, лабораториуд | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Магадлан итгэмжлэгдсэн: -Өрхийн ЭМТ-ийн тоо - Хувийн хэвшлийн эмнэлгийн тоо -эмийн сангийн тоо -Сувиллын тоо - лабораторийн тоо | "Эрүүл мэндийн үйлчилгээний төрлийн тоо 25 - Мэдээллийн цахим сангийн баяжилтийн хувь 100 - Цахим сүлжээний орчин | Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж ,чанар сайжирна. | | Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 15 сум, 6 тосгон, 5 өрхийн эрүүл мэндийн төвийг өөрсдийн нөөц, боломжид тулгуурлан үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдүүлэн өрөөг тохижуулж тусгай хэрэгцээт 350 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | | ын үйл ажиллагааг дэмжиж ард иргэдэд хүрч үйлчлэх боломжийг нь бүрдүүлнэ. | | | | бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь 100 | | | Аймагт хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн 5 өрхийн эрүүл мэндийн төв, 5 хувийн хэвшлийн эмнэлгүүдээр 13331 иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Мөн 2 ариутгал халдваргүйжүүлэлтийн байгууллага, 3 эмнэлзүйн лабораторийг ажиллуулж байна. | |
| 27 | | 2.2.6. Мэргэжлийн өндөр ур чадвартай, туршлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтныг гэрээний тусгай нөхцөлтэйгээр ажиллуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Бэлтгэгдсэн эмнэлэгийн ажилтны хангалтын хувь -Олон нийтийн ойлголтын болон сэтгэл ханамжийн тандалтын хувь | Бэлтгэгдсэн эмнэлэгийн ажилтны хангалтын хувь 27 - Олон нийтийн ойлголтын болон сэтгэл ханамжийн тандалтын хувь 100 | Санхүүгийн болон хүний нөөцийн асуудлаар бие даасан байдал хангагдана. | | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Улаанбаатар хотоос томографын шинжилгээг хийх мэргэшсэн дүрс оношилгооны 1 их эмч, 1 нүдний эмч, Ерөө сумын эрүүл мэндийн төвд 1 шүдний их эмч, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг 1 Дурангийн их эмч, 1 эмгэг судлаач эмч , 2 шүдний эмч, Сайхан сумын эрүүл мэндийн төвд дүрс оношилгоо судлалын 1 их эмч тус тус гэрээний тусгай нөхцөлтэйгээр ажиллаж байна. | 90 |
| 28 | | 2.2.7. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл хүүхэд-Эрүүл Ирээдүй” эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эрүүлжүүлэх | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Үзлэгийн тоо - Түүнд хамрагсдын тоо | Үзлэгийн тоо 135 - Түүнд хамрагсдын тоо | Нүдний өвчлөлтэй суралцагчид эрүүлжсэн байна. | | Хүн амын нас хүйс, эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээ”-нд 0-17 насны 2 багц эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 37981 хүүхэд хамруулахаас 25507 хүүхдийг хамруулан, гүйцэтгэл 67,2 байна.<br>Мөн хүүхдийн нүдний өвчлөлийг илрүүлэх анхан шатны үзлэгийг харааны таблец ашиглан зохион байгуулж, харах чадварын бууралттай 465 хүүхэд | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | | оношлогдон лавлагаа шатлалын эмнэлэгт илгээн шинжилгээнд хамруулж холбогдох эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлсэн. | |
| 29 | | 2.2.8.“Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн төв”-ийг байгуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Тусгай хэрэгцээт хүүхдийг оношлох, эмчлэх, сувилах, сэргээн засах эмч, мэргэжилтний тоо -Түүнд хамрагдсан хүүхдийн тоо | - | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээнд хамрагдах боломж бий болно. | | Сүхбаатар сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийг сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж тус сумын хөрөнгө оруулалтаар 204.6 сая төгрөгийн засвар үйлчилгээ, тус сумын Иргэдийн Төлөөллөгчдийн хурлын шийдвэрээр 19.5 сая төгрөг, Тайван улсын хүүхдийн сан 5 сая төгрөг, Дэлхийн зөн Олон Улсын Байгууллага 5 сая төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.93 сая төгрөгийг тусгай хэрэгцээт хүүхдийн сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмж, массажны ор, тоглоом зэргийг нийлүүлж дэмжлэг үзүүлсэн. Тус хүүхдийн сувилалд нийт 75 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж, тухайн чиглэлээр мэргэшсэн орон тооны 1 их эмч эмчлэх, сувилах, сэргээн засах үйлчилгээг үзүүлж байна. | 90 |
| 30 | | 2.2.9. Мандал суманд хүүхдийн эмнэлэг байгуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Ашиглалтад орсон барилга | - | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ сайжирна. | | Мандал суманд хүүхдийн эмнэлэг байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, төрийн худалдан авах ажиллагааны газраас уг тендерийн үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулсан болович тендерт оролцохоор баримт бичгээ | 50 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага байхгүй байсан тул тус арга хэмжээг зохион байгуулах боломжгүй байна. | |
| 102 | | 5.1.2. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх шууд утсыг төр, төсвийн | 2021 - 2025 | Тухайн байгууллагын төсөв | Байгууллагын тоо Шийдвэрлэлтийн хувь | 1 87,9 | 17 93,0 | | Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх 7036-1111 шууд утсыг аймгийн Засаг даргын Тамгын газарт, Мандал сум 7036-7010, Цагааннуур сум 7036-6666 утсыг тус тус ажиллуулж байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 103 | | болон хувийн хэвшлийн байгууллагууд ад ажиллуулж, иргэдийн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэнэ. | | | | | | | Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт аймгийн хэмжээнд 2021 онд 5471, 2022 онд 3522, 2023 онд 3555 өргөдөл, гомдол ирсэнийг 2021 онд 93.6, 2022 онд 97.0, 2023 онд 97.3 хувьтай тус тус шийдвэрлэсэн. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол 2022 онд 3522 ирсэн нь өмнөх оноос 1949-өөр буюу 35.6 хувиар буурсан бол 2023 онд өмнөх оноос 33-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Нийт ирсэн өргөдөл гомдлыг агуулгаар авч үзвэл газрын харилцаа, иргэдийн төрсний бүртгэл, регистрийн дугаарын зөрчил, цахим үнэмлэхээ сунгуулах, шилжилт хөдөлгөөн, бүртгэлийн хугацаа хэтэрсэн газар тариалан, хадлангийн талбайн зөвшөөрөл болон нийгмийн халамжид хамрагдахыг хүссэн, мөнгөн тусламж, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар тавьсан хүсэлт дийлэнх хувийг эзэлж байна. 2022 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 14 байсан бол 2023 онд 12 хоног болгон буурууллаа. | |
| 103 | | 5.1.3. ОХУ, БНХАУ болон хамтын ажиллагаатай | 2021 - 2025 | Тухайн байгууллагын төсөв | Хамтын ажиллагаатай хот, мужийн тоо | 12 | 15 | | Уламжлалт хамтын ажиллагааны хүрээнд болон шинэ түншлэлийг эрэлхийлэн 2021-2022 онд Германы хамтын ажиллагааны | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бусад улс, муж, хотуудтай харилцаагаа бэхжүүлж, шинэ түншлэлийг нэмэгдүүлнэ. | | | | | | | Хайнс зайделийн сантай Хууль эрх зүйн чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлаад байна. Мөн Австрали Улсын Элчин сайдын яамны санаачлагаар тус улсын боловсролын салбартай хамтран ажиллах тэр дундаа дээд шатны боловсролын тэтгэлэгт хөтөлбөрүүдийг аймаг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. БНСУ-ын Сөүл хотын Үньпён дүүрэгтэй төрийн захиргааны чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Мөн уламжлалт хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Дангжин хоттой харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн байгуулж, Сэлэнгэ аймгаас улирлын чанартай ажилтанг гэрээгээр гаргах ажлуудыг хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.<br>Түүнчлэн 2023 онд “Гадаад харилцааг эдийн засагжуулах нь” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж БНБУ-ын тэргүүн Алексей Самбуевич Цыденовтой 2 удаагийн хэлэлцээр хийж, боловсрол, соёл, эрүүл мэнд, худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллахаар тохиролцсон бөгөөд ОХУ-ын БНБУ-ын Боловсрол, шинжлэх ухааны сайдын үүргийг | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | орлон гүйцэтгэгч Поздняков Валерий Анатольеивич тэргүүтэй боловсролын байгууллагын төлөөлөгчид албан айлчлал хийж, уулзалт зохион байгууллаа. Аймаг, орон нутгийн зүгээс аймагтаа хүүхэд, залуучуудын орос хэл сурах идэвхийг өрнүүлж Буриад улсад сурах хүсэлтэй оюутнуудад хөнгөлөлт үзүүлэх, орос хэлний багш нарыг бэлтгэх, дадлагажуулах, хилийн ойр бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, хавдарын цөмийн эмчилгээний төвтэй хамтран ажиллахаар болсон. АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран тус улсын “Америкийн соёл мэдээллийн төв”-ийг Сэлэнгэ аймагт байгуулахаар ажиллаж байна.<br>Канад Улсын Эрүүл мэндийн салбарын нүдний нарийн мэргэжлийн эмч нартай хамтран аймгийн нийт ард иргэдэд үзлэг оношлогоо эмчилгээг үзүүлж хамтран ажиллалаа.<br>Сөүл хотын Үньпён дүүрэгтэй эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах, Япон Улсын Шизоука мужийн Озава тент ХХК-тай хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт тус улсын технологийг нэвтрүүлэх, нарийн ногооны өвлийн хүлэмж байгуулах, орчин үеийн инновац нэвтрүүлэхэд | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хамтран ажиллахаар харилцан тохиролцоод байна.<br>БНХАУ-ын Хар мөрөн мужийн Харбин хоттой аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тус хотын Мөсөн урлалыг Сэлэнгэ аймагт орон нутгийн онцлог төрхийг шингээсэн арга хэмжээг зохион байгуулах, туршлага судлахаар саналыг хүргүүлээд байна. | |
| 104 | 5.2. Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг үе шаттай хэрэгжүүлнэ. | 5.2.1. Ерөө сумын Бугант тосгоны төр төсвийн байгууллагуудыг шилэн кабельд холбож, хүн амыг өндөр хурдны интернетийн үйлчилгээгээр хангана. | 2021 - 2025 | 20 сая төгрөг Орон нутгийн төсөв | -Интернетийн хурдны хэмжээ | 2 Мв | Тосгоны хэмжээнд өндөр хурдны интернетийн үйлчилгээг үзүүлсэн байна. | | “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын хүрээнд Ерөө сумын Бугант тосгоныг Ерөө сумаас 75 км-ийн шилэн кабельд холбох ажлыг хийж гүйцэтгэн тосгоны Захирагчийн албанд хүлээлгэн өгсөн.<br>Мөн интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай шинэчилсэн гэрээ байгуулан интернетийг 5Мв-ийн бодит хурдаар авч хүн амд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх ажлыг зохион байгуулсан. | 100 |
| 105 | | 5.2.2. Аймаг, сумын хэмжээнд “E-Mongolia” үйлчилгээг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг операторийн горимоор | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв /35.0 сая төгрөг/ | -Нийт үзүүлсэн үйлчилгээний тоо | 9166 | Нэг цэгээс төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ. | | Монгол Улсын Засгийн газрын “Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 149 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 17 суманд төрийн үйлчилгээг операторын горимоор цахимаар түргэн шуурхай хүргэх үйлчилгээг амжилттай нэвтрүүлж 1 шатлалт 54 үйлчилгээг үзүүлж байсан бол Засгийн газрын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үзүүлэх ажлыг тогтмолжуулна. | | | | | | тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын “E-Mongolia” төслийн нэгжтэй хамтран 2 шатлалт үйлчилгээг 2021 онд зохион байгуулж, аймгийн хэмжээнд 15 байгууллагын 73 нэр төрлийн 269 үйлчилгээг үзүүлж байсан бол 2023 онд 9 байгууллагын 19 төрлийн үйлчилгээг нэмж нэвтрүүлсэн.<br>www.e-mongolia.mn -ээр 2021 онд 5084, 2022 онд 11287, 2023 онд 11548 иргэнд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүндрэлгүй цахимаар хүргэсэн нь жил бүр өссөн үзүүлэлттэй байна. Мөн аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 18 үйлчилгээнд urban.gov.mn систем, Эрүүл мэндийн газрын 8 үйлчилгээнд “Эрүүл мэндийн бүртгэл, зөвшөөрлийн систем”-д холбосон. | |
| 106 | | 5.2.3. Төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төрийн байгууллагын ажил үйлчилгээг цаасан суурьт | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | -Цаасан болон цахим сэтгүүлийн тоо | - | Цаасан болон цахим сэтгүүлийг 10000 хэвлүүлсэн байна. | | 2022, 2023 онд аймгийн Засаг даргаас төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, орон нутаг дахь сэтгүүлчидтэй нийт 165.9 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулж, төрийн ажил үйлчилгээг сурталчилсан.Гэрээт байгууллагуудаар дамжуулан давхардсан тоогоор 4540 мэдээ мэдээлэл, ярилцлага, тодруулга, шууд дамжуулалтыг иргэд олон | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | болон цахим сэтгүүлээр нийтэд сурталчилна. | | | | | | | нийтэд түгээн сурталчилсан. Төр төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимд шилжсэн энэ хугацаанд төрийн ажил үйлчилгээний мэдээ мэдээлэл бүхий “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлийн 4 удаагийн дугаарыг 4000 ширхэгээр бэлтгэн гаргаж иргэд олон нийтэд түгээсэн. Сэтгүүлийн хэвлэлтэд нийт 31.0 сая төгрөгийг зарцуулсан. | |
| 107 | | 5.2.4. Иргэд олон нийтэд мэдээллийг ил тод, хурдан шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэн, аймаг, орон нутгаас тодорсон алдартан гавьяатан, шинийг санаачлагч, баялаг бүтээгчдийг алдаршуулна. | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | -Иргэдэд хүргэсэн мэдээллийн тоо | - | Иргэд олон нийтэд мэдээллийг ил тод, хурдан шуурхай хүргэж мэдээллэсэн байна. | | МҮОНТ-тэй хамтран “Агуу түүх Алтанбулагаас” нийтлэл уран сайхны нэвтрүүлэг /1 цаг/, “Шивээ Хиагт” теле дуурь /1 цаг 30 минут/, “Цэнгэлийн манлай” /30 минут/, “Ардын хувьсгалын чацуутан” хөрөг нэвтрүүлэг /20 минут/ , “Нутагтаа сайхан амьдаръя” Шаамар сумын Дулаанхаан тосгоны өрхийн аж ахуйтан Д.Отгонбаяр /20 минут/, “Аялалын тойрог” нэвтрүүлгийн продюсер Ц.Ган-Өлзийтэй хамтран 17 сумын байгалийн үзэсгэлэнт газар нутаг, хүн зоны ажил амьдрал, өрхийн үйлдвэрлэгчид, орон нутгийн онцлог давуу талыг харуулсан тус бүр 50 минутын 5 удаагийн дугаарыг бэлтгэн UBS, Өлзий, E-TB, ТВ-6, Малчин, Оргил телевизүүдийн эфирээр 2-3 удаагийн давтамжтайгаар гаргаж олон нийтэд сурталчлан аялагч жуулчдыг уриалан дуудлаа. “Тэйк оф” ХХК-ийн захирал | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Д.Баясгалантай хамтран 17 сум, 6 тосгоны шилдэг өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдээ “Сумандаа сайхан амьдаръя” зорилтот нэвтрүүлгээр алдаршууллаа. “Номайдик энтертейнмент”ХХК-тай хамтран Сэлэнгэ аймгийг илтгэн харуулах түүх соёл, байгалийн үзэсгэлэнт газруудын фото зургийг бэлтгэлээ. Төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээний дэлгэрэнгүй ярилцлага, тойм мэдээллийг “Хөгжил зүтгэл” сэтгүүл, “Зууны мэдээ, “Монголын үнэн” сонин, хөдөө аж ахуйн мэдээ мэдээллийг “Ургадаг алт” сэтгүүлээр дамжуулан улс орон даяар түгээн сурталчилж хамтран ажиллалаа. Мөн төр түмэндээ үнэлэгдсэн баялаг бүтээгч шинийг санаачлагч хөдөмөрийн сайчуудын 29 удаагийн ярилцлага, нийтдээ 61 удаагийн нэвтрүүлэг, ярилцлага бэлтгэн Сэлэнгэ аймгийнхаа баялаг бүтээгчдийг алдаршуулах, нутаг орноороо бахархах, аялагч жуулчдыг урин дуудаж соён гэгээрүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. | |
| 108 | | 5.2.5. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд ын ажилтнуудын | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | -Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн хэвлэл мэдээллийн | - | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуу дын ажилтнуудын | | Орон нутгийн “Миний Монгол”, “Сэлэнгэ цахим” ТВ, Монцамэ, ММ агентлагийн орон нутаг дахь сэтгүүлчдийг: АТГ-аас зохион байгуулсан 4 удаагийн, ТАЗ-өөс зохион байгуулсан 3 удаагийн, | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдлэг, ур чадварыг сайжруулж, улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. | | | байгууллага, сэтгүүлчийн тоо | | мэдлэг, ур чадварыг сайжруулсан байна. | | Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн эвлэлээс зохион байгуулсан 2 удаагийн, “Глоб интерншл” ТББ-аас зохион байгуулсан 1 удаагийн цахим, 2 удаагийн танхимын нийтдээ 12 удаагийн сургалтад хамруулж, шинэ мэдлэг мэдээлэл олголоо. Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн эвлэлээс цахим хэлбэрээр зохион байгуулсан сэтгүүлчдийн форумд Сэлэнгэ аймаг дахь сэтгүүлчдийг оролцуулах танхим, орчин нөхцөлийг бүрдүүлж Сэтгүүлчдийн Нэгдсэн эвлэлийн салбар зөвлөлтэй хамтран ажилласан. | |
| 109 | 5.3. Мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, чадахуйн зарчимд тулгуурласан ухаалаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ. | 5.3.1. Төрийн байгууллагуудад чадахуйн зарчмыг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ. | 2021 - 2025 | - | -Шатлан дэвшсэн төрийн албан хаагчдын тоо, хариуцлага хүлээсэн албан хаагчдын тоо | 53 | 25 | | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудад нийт 118 ёс зүйн зөвлөл шинэчлэгдэн ажиллаж, төрийн захиргааны болон үйлчилгээний 27 албан хаагчид ёс зүйн зөрчил гаргаж, хариуцлага тооцсон.<br>Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газраас Канад Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх | 50 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нь” төслийн хүрээнд “Стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага”, “Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” дэд төсөлд хамрагдахаар сонгогдож, төслийг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын дарга, нэгжийн дарга, ахлах мэргэжилтнүүд, залуу төрийн албан хаагчд, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүдийг менторшип хөтөлбөрт хамруулсан.<br>Аймгийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын удирдах албан хаагчид, ёс зүйн зөвлөлийн гишүүд 100 хүнийг хамруулан “Төрийн албаны үнэт зүйл-эрүүл мэндийн ажилтнууд” зөвлөгөөнийг зохион байгуулсан.<br>Албан хаагчдын цаг баримтлалт, сахилга хариуцлага, соёлжилтод хяналт тавьж ёс зүй, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.<br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан ёс зүй, харилцаа хандлага, аз жаргалтай ажилтан, амжилтанд хүрэх хүсэл зэрэг 7:4:10 онлайн сургалт, “Best” сургалтын төвтэй хамтран “Эерэг | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | харилцаа хандлага сургалт”-нд 84 төрийн албан хаагч хамруулсан.<br>Ёс зүйг эрхэмлэх аяныг “ТАЛАРХАЛ-ЭЕРЭГ ХАНДЛАГА” нэртэйгээр мэндлэх хүндлэх, талархах сайхан харилцааг өдөр тутамдаа хэвшүүлэх, байгууллагын имиж болгон Талархлын үгтэй хамгийн олон эможи авсан 2 албан хаагчийг урамшуулсан.<br>“Ёс зүйн зөрчилгүй сум” аяныг зохион байгуулж, сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн албан хаагчид, ёс зүйн дэд хороод идэвхитэй оролцож, Төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэгийг дээшлүүлсэн. | |
| 110 | | 5.3.2.”Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах”, “Суралцагч байгууллага-төрийн албаны манлайлал” хөтөлбөрийг төрийн байгууллагууд ад хэрэгжүүлнэ. | 2021 - 2025 | Тухайн байгууллагын төсөв | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 84.5 | 90.0 | | **“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа”** аймгийн хөтөлбөрийн эхний шатны хэрэгжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, 2021 оны 40 дүгээр тогтоолоор 86,7 хувь буюу хангалттай үнэлгээгээр дүгнэгдсэн.<br>Төрийн байгууллагуудын үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор шинэ барилга байгууламж барих чиглэлээр 12.7 тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүчин чадлыг сайжруулах чиглэлээр 2.4 тэрбум төгрөг, эрүүл | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | мэнд, төрийн тусгай албаны орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 1.0 тэрбум төгрөгийн 94 ажил арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн.<br>**“Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал”** аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 43 ажил, арга хэмжээтэйгээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Нийгмийн хариуцлагын гэрээгээр Хүдэр суманд “Тайгын саарал чоно”, “Хүдэр амжаа” компаниуд хамтран “Төрийн албан хаагчдад зориулсан байр”, Баруунбүрэн суманд аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 4 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, хөдөө орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Биеийн тамир, спортын газрын гадна фасадны засвар, Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засварын ажлууд хийгдэж, аймгийн Татварын хэлтсийн барилга бүрэн дуусч, Сүхбаатар хилийн боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор ашиглалтад орж, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй хил, гаалийн байгууллагуудын | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах арга хэмжээг авч байна.<br>2022 оны жилийн эцсийн байдлаар Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвөөс санхүүжиж буй төрийн байгууллагуудад ажиллаж байгаа төрийн албан хаагчдад **11900,4** сая төгрөгийн цалин урамшуулал, **450,8** сая төгрөгийн тэтгэмж тусламж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн албан хаагчид **248,8** сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг тус тус олгож, аймгийн Засаг даргын 2022 онц 3 дугаар сарын 28-ны өдрийн А/95 тоот захирамжаар төрийн захиргааны 27 байгууллагын 183 албан хаагчид **төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв**ийг шинээр болон ахиулан олголоо.<br>Сүхбаатар хилийн боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор барилга ашиглалтад орсонтой холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын хойд бүс дэх газрын ажилтан, албан хаагчдын компьютер техник хэрэгслийг шинэчлэхэд 49,5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ.<br>Мал эмнэлэгийн газарт малын шилжилт хөдөлгөөнийг хянах, малын хулгайтай тэмцэх, мал, амьтны халдварт өвчнийг тандах, | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тэмцэх, арга хэмжээг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийн санг бүрдүүлэх цогц системийг нэвтрүүлэхэд 75,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, техник тоног төхөөрөмжөөр хангалаа.<br>2023 онд сум орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх зорилгоор сумдын ЗДТГ болон багийн Засаг дарга нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр "Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн"-ий үеэр 17 сумын ЗДТГ-ын дарга нар болон 57 багийн Засаг дарга нарт 163.9 сая төгрөгийн үнэ бүхий суулийн үеийн зөөврийн компьютер хүлээлгэн өгч үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг хангах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээг чанартай шуурхай үзүүлэх зорилгоор 131.4 сая төгрөгийн үнэ бүхий сүүлийн үеийн үзүүлэлт бүхий иж бүрэн компьютер, хэвлэгч, хувилагч, иж бүрэн дрон зэрэг тоног төхөөрөмжөөр хангасан. | |
| 111 | | 5.3.3. Аймгийн хэмжээнд “Чанарын чуулган” зохион | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв, жил бүр шагнал | Шагнал хүртсэн байгууллагын тоо | Үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэнэ. | Хэрэглэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ. | | Аймгийн хэмжээнд 2021 оныг “Чанарыг эрхэмлэх жил” болгон зарласантай холбогдуулан орон нутгийн хэмжээнд бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжийг | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж, “Чанарыг эрхэмлэгч байгууллага” шагналыг бий болгон үйлчилгээний чанарын стандартыг орон нутагт хэрэгжүүлнэ. | | д 5.0 сая төгрөг | | | | | дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн сэтгэл ханамжид нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээгээр хангах, үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор “Чанарыг эрхэмлэгч байгууллага” шагналыг бий болгон журмыг боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулсан.<br>“Чанарыг эрхэмлэгч байгууллага” шагналын журмын дагуу шалгаруулалтыг зарлан “Цемент шохой” ТӨХК болон “Хүчү агро” ХХК-ийг 2022 онд шалгаруулж батламж, 2 сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан. | |
| 112 | 5.4. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэх мэдээллийн дэд бүтцийг хэрэглээнд нэвтрүүлнэ. | 5.4.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Сэлэнгэ хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан”-г нэвтрүүлнэ. | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | -Мэдээллийн санд холбогдсон байгууллагын тоо | - | баримт бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Сэлэнгэ хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санд 40 байгууллагын мэдээллийг байршуулсан байна. | | “Сэлэнгэ хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан”-г нэвтрүүлэхээр “Ухаалаг засаглал” төрийн бус байгууллагатай хамтран санал солилцож, “Орон нутгийн мэдээллийн дэд бүтэц” төслийг боловсруулсан. Тус төсөлд нэвтрүүлэлтийн зардлыг 14.5 сая төгрөг, хамтын ажиллагааны буюу үйл ажиллагааны зардлыг 24.9 сая төгрөгөөр тус тус тооцож санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Олон Улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудад хандсан. Тус ажлыг хэрэгжүүлэхээр аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан. | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 113 | | 5.4.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт төлөвлөлтийн, явцын, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, нутгийн захиргааны байгууллагуудын менежментийг сайжруулна. | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бодлогын баримт бичгийн тоо | - | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт төлөвлөлтийн, явцын, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ хийсэн байна. | | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт төлөвлөлтийн хэрэгжилт болон хэрэгжиж дууссан үндэсний болон аймгийн нийт 18 бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг тооцон, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланг салбарын яамдад хүргүүлсэн.<br>2023 онд аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд өв соёл, соёлын бүтээлч үйлдвэрлэл, боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, инноваци, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийтийн биеийн тамир, санхүү, засаглал, зэвсэгт хүчин, хууль сахиулах, хөдөө аж ахуйн, байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын чиглэлийн салбаруудыг багтаан **8** бүлгийн хүрээнд нийт **192** арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнээс өмнөх оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөс үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа **122** арга хэмжээ, шинээр төлөвлөсөн **70** арга хэмжээ, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг **5** бүлгийн **169** зорилттойгоор боловсруулан, батлуулж | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хэрэгжилтийг ханган ажиллаж, нийт 169 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 112 зорилт 100 хувь, 16 зорилт 90 хувь, 21 зорилт 70 хувь, 11 зорилт 50 хувь, 7 зорилт 30 хувь, 2 зорилт 0 хувь буюу дунджаар **91.5 хувийн** гүйцэтгэлтэйгээр үнэлэгдсэн. | |
| 114 | | 5.4.3. Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж буй арга хэмжээнүүдийн үр нөлөөнд дотоод аудит хийх замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийн тоо | - | Дотоод аудит хийх замаар эдийн засгийн үр ашиг дээшилсэн байна. | | Органик хөдөө аж ахуйн түншлэл төсөлийн хүрээнд Газар тарилангийн тоног төхөөөрмж 193,960,170 нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйдвэрлэх тоног төхөөрөмж (ногоо даршлах нөөшлөх, зөгийн бал савлах, талх нарийн боов, оёдол, эсгий бүтээгдэхүүн, органик бордоо үйлдвэрлэх,мах ангилан ялгах гм 33 цех) 150,506,494, Органик үр бордоо 78,962,305, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт-169,300 ширхэг сав баглаа боодол,140,280 ширхэг шошго 72,700,600, нийт 496, 129, 569 төргийн шууд хөрөнгө оруулалт хийж ажилласан байна.<br>АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Best хөтөлбөр, иргэдэд 50 сая төслийн буцалтгүй тэтгэлэг олгосон, 17 сумдад 110 удаагийн сургалт, уулзалтыг 3012 хүнийг хамруулан зохион байгуулж, 3 тэрбум, 530 сая төгрөгийн зээл авахад туслаж дэмжин ажилласан байна. Дэлхийн зөн Монгол Олон Улсын | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байгууллага нь 3 хөтөлбөрийн хүрээнд 1.3 тэр бум төгрөгийн санхүүжилтээр төсөл арга хэмжээнүүдийг 7 сум 2 тосгонд хэрэгжүүлэн ажилласан. Тогтвортой амьжиргаа-3 төсөл ОНХС-ын гүйцэтгэлд урамшуулал олгож 2016-2023 онд 3,073,560.5 төгрөгийн урамшуулал олгож ажилласан байна. | |
| 115 | | | 5.4.4. Нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах ажлыг эхлүүлнэ. | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | -Чиг үүргийн шинжилгээ хийсэн байгууллагын тоо | - | Чиг үүргийн шинжилгээ хийж ажил үүргийн давхцалыг арилгасан байна. | | "Цэнгэг Ус", "Цант-Орхон", "Гавшгай-Ус", "Сэлэнгэ-Энерго", "Цөм сүрэг", "Барилга захиалагч", "Сэлэнгэ Орон сууц" зэрэг 7 ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын батласан удирдамжийн дагуу чиг үүргийн шинжилгээ, дотоод аудит хийж, зөвлөмж, албан шаардлагуудыг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.<br>Дотоод аудитаар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд нь их хэмжээний өр үүссэн, хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл учирч байгаа нь нийгмийн суурь үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжид хүргэхэд томоохон хүндрэл үүсгэж байна. | 100 |
| 116 | | | 5.4.5. Орон нутгийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ, | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | -Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо | - | Орон нутгийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ, | | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг сум, тосгодод зөвлөн туслах, хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж, 17 сумдад ажилласан ажлын хэсгүүд сумдын Засаг | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтнүүдийн мэдлэг ур, чадварыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. | | | | | дотоод аудит хариуцсан мэргэжилтнүүдийн чадавх сайжирсэн байна. | | даргын Тамгын газрын тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнүүд болон төсвийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад анхан шатны Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн сургалтыг зохион байгуулан ажилласан. | |
| 117 | | 5.4.6. Засаг захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг дэмжих замаар төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чанартай болгох, багийн чадавхыг бэхжүүлэх, баг, иргэд хоорондын харилцааг идэвхжүүлэн тэдгээрийн эрэлт хүсэлтийг шуурхай шийдвэрлэнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Шинээр бий болгосон багийн байрны тоо | - | Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай чанартай үйлчилгээ үзүүлэх багийн байр бий болсон байна. | | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Алсын хараа 2050", “Хөдөөгийн сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймаг “Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээний хүрээнд 57 багийн чадавхийг нэмэгдүүлэх, иргэд хоорондын харилцааг идэвхжүүлэх зорилгоор багийн хөгжлийг дэмжих зорилгоор төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг анхан шатны нэгж буюу багийн хөгжлийг дэмжих зорилгоор үйлчилгээг шат шатнадаа түргэн шуурхай үзүүлж байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 303 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багийн Засаг дарга нарыг чадавхжуулах, иргэн төвтэй хөгжлийн үзэл баримтлалыг түгээж засаг захиргааны анхан шатны нэгжийн удирдлагын хандлагыг өөрчлөх, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд шаардлагатай мэдлэгийг дээшлүүлэх, ур чадвар | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эзэмшүүлэх зорилгоор багийн Засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг 17 сумдын 57 багийн Засаг дарга нарыг 2024 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд сургалтад хамруулахаар бэлтгэл ажлыг эхлүүлэн ажиллаж байна. | |
| 118 | 5.5. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах бодлого хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ. | 5.5.1. Аж ахуйн нэгж, хувийн хэвшил дэх хүний эрхийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө, төсөл хөтөлбөр | -Аж ахуйн нэгжийн тоо | 83.1 | 84.2 | | Аймгийн Засаг даргын 2021 оны “Олон улсын “Хүний эрхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай А/373 дугаар захирамжаар Монголын Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн туслалцааны төв, аймгийн хууль сахиулах байгууллагуудтай хамтран “Хүний эрхийн өдөрлөг” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, иргэдэд хууль сурталчлан, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.<br>“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний 2020-2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, “Шинээр батлагдсан хууль, тогтоомж, хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт”-ыг Алтанбулаг, Шаамар, Баруунбүрэн, Орхон, Орхонтуул, Сант, Сүхбаатар, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумдын 258 иргэд, төрийн албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж, | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хүний эрхийн мэдлэг хандлагыг дээшлүүлэн ажиллалаа.<br>Сүхбаатар сумын “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын захиралд холбогдолтой Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүнээс ирүүлсэн шаардлагад дурьдагдсан хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамтаас ангид байх эрх зөрчигдөхөд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах, хариуцлагыг дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, мэдээлэх, сургалт зохион байгуулан ажилласан. | |
| 119 | | 5.5.2. Хууль тогтоомж сурталчлах, зөвлөгөө өгөх “Эрх зүйн хөтөч”-ийг багуудад ажиллуулах асуудлыг судлан, хууль, эрх зүйн албан бус сургалт зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хүртээмжтэй, ойлгомжтой | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | Аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 80% | 85% | | “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрх зүйн хөтөч нарыг үйл ажиллагаа явуулахад нь удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах талаар аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд тусган хэрэгжилтийг хангаж ажилласан. Хууль тогтоомж сурталчлах зөвлөгөө өгөх эрх зүйн хөтчийн нэгдсэн мэдээллийг шинэчлэн, “Ханнс Зайделийн сан”, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран эрх зүйн хөтөч нарыг давтан сургах сургалтыг 2021, 2022 онд “Эрх зүйн хөтөчийн чадавхжуулах | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэлбэрээр зохион байгуулж, сургалтын үйл ажиллагаа нь зорилтот бүлгүүдэд хүрсэн байх нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | сургалт”-ыг зохион байгуулж, 17 сум, 6 тосгоны 95 эрх зүйн хөтөчийг хамруулж, сертификат олгосон.<br>Аймгийн Засаг даргын 2023 оны “Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөө, захиргааны шийдвэр хянах хуваарь батлах тухай” А/304 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын дагуу 17 сум 6 тосгодын эрх зүйн хөтөч нар 256 удаагийн сургалтаар 18.5 мянган иргэд, төрийн албан хаагчдад хууль, эрх зүйн албан болон албан бус сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.<br>Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 17 сум 6 тосгонд “Эрх зүйн хөтөчийг чадавхжуулах цахим сургалт”-ыг 17 эрх зүйн хөтөч, үндсэн хуулийн дугуйлан төслийг үргэлжлүүлэхээр 45 сургагч багш бэлтгэсэн. | |
| 120 | | 5.5.3. “Хууль зүйн туслалцааны төв”-ийг бүсийн төвүүдэд байгуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө, төсөл хөтөлбөр | -Судалгаанд оролцогчдын тоо Хууль зүйн туслалцаа авсан иргэдийн тоо | Эрүү, иргэн, захиргааны чиглэлээр тус тус өмгөөлөгч ажиллаж төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчлэх хүрээ нэмэгдэнэ. | Иргэдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, анхан шатны хууль зүйн зөвлөгөө дэмжлэгийг авсан байна. | | Монгол Улсын Үндсэн хуулинд тусгалаа олсон хууль зүйн туслалцаа авах эрх, төлбөрийн чадваргүй иргэдийн эрхийг хангах үүднээс Хууль зүйн туслалцааны төвийг Сүхбаатар, Мандал суманд “Иргэдэд үйлчлэх танхим” нэртэйгээр байгуулан Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбооны өмгөөлөгч нар иргэдэд үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгч, хууль | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ёсны эрх ашиг сонирхлыг нь хамгаалан ажиллаж байна<br>“Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хуулийн хэрэгжилтийг ханган 2 өмгөөлөгчийг иргэд, олон нийтэд хууль зүйн ажил үйлчилгээг үзүүлэх өрөө тасалгаа, техник хэрэгсэл, интернетээр хангаж, хөрөнгө санхүү, удирдлага зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>2022 онд Улсын өмгөөлөгчөөс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 53 хэргийн 56 төлбөрийн чадваргүй иргэнд нийт 375 иргэнд хууль зүйн зөвлөгөө, 2023 онд мөрдөн байцаалтын 42 хэргийн 52 төлбөрийн чадваргүй иргэнд нийт 170 иргэнд хууль зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн. | |
| 121 | 5.6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлагыг төлөвшүүлнэ. | 5.6.1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө, төсөл хөтөлбөр | -Гэмт хэрэг, зөрчлийн тоо | Аймгийн шударга байдлын үнэлгээ 2019 онд 77.0 оноогоор үнэлэгдсэн. | Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн тоо буурсан байна. | | 2021 онд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн нь тогтоогдсон 1, 2022 онд 2 албан тушаалтанд хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож, дээрх зөрчлийг дахин гаргуулахгүй байх, сумын төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.<br>2021, 2022 онд Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь цахим сургалт”, “Авлигын шалтгаан, хор хөнөөл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сургалт”-нд 411 албан хаагчийг оролцуулан зохион байгуулсан.<br>2022 онд Авлигатай тэмцэх газартай хамтран “Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье” өдөрлөгийг зохион байгуулж, 24 агентлагийн 90 төрийн албан хаагч, 8 багийн 140 иргэн, 6 сургуулийн 287 сурагчид, 17 сум, 24 агентлагт “Авлигын эсрэг хамтдаа” сэдэвт урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг Авлигатай тэмцэх газарт тайлагнан ажилласан.<br>2022 онд шинээр төрийн албанд томилогдсон 128, 2023 онд 48 төрийн албан хаагчийн судалгааг гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, анхан шатны сургалтад цахим хэлбэрээр хамруулсан.<br>Авлигатай тэмцэх газартай хамтран “ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн бэлтгэл ажлыг хангах тухай ЭБАТ-уудад зориулсан цахим сургалт”-нд 22 эрх бүхий албан тушаалтан, 24 | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | удаагийн “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сургалт”-ыг 8 сум, 3 тосгон, 12 байгууллагын 1012 албан хаагчийг оролцуулан 800 гаруй зурагт хуудас, гарын авлагыг тараан зохион байгуулсан. | |
| 122 | | 5.6.2. Олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж, шударга ёсны тогтолцоог төлөвшүүлэх ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө, төсөл хөтөлбөр | -Арга хэмжээний тоо -Оролцогчдын тоо | 70 орчим контентуудыг 22 агентлаг, 17 сум, 6 тосгодод иргэд, олон нийтэд хүргэн, нийт 889 иргэнд 1000 гаруй тараах материалыг олгон соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан. | Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн тоо буурсан байна. | | Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах, ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Шударга удирдагч, шударга төрийн албан хаагч” аяныг аймгийн Засаг даргын 2021 оны А/292 дугаар захирамжаар аяныг өрнүүлж, Авлигатай тэмцэх газартай хамтран аяны нээлт, “Авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалт”,<br>“Авлигын эсрэг хамтдаа сургалт”-ыг 20 удаа цахим болон танхимаар 24 агентлаг, 17 сум, 6 тосгоны 1120 төрийн албан хаагчдад оролцуулан зохион байгуулж, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” гарын авлагыг тараан, аймаг, сум, байгууллагуудын цахим | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хуудсуудаар Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан шторк, теле зохиомж, контентийг дамжуулан иргэд олон нийтэд түгээн сурталчилсан.<br>Сумдын Засаг дарга нараас аймгийн Засаг даргад “Авлига, ашиг сонирхлын болон санхүү, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллах баталгаа”-г гарган ажилласан.<br>2023 онд нийтийн албан тушаалд шинээр томилогдохоор нэр дэвшсэн аймгийн Засаг даргаас томилдог 6, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 4 нийт 10 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр хянуулах ажлыг зохион байгуулж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлтийг аймгийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд ил тод мэдээлэн ажилласан.<br>Шил ажиллагааны www.shilen.gov.mn-д хуулийн төсөл, захиргааны хэм хэмжээний актад өгсөн санал, тэдгээрийн танилцуулга, Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, 2022, 2023 онд шинээр томилогдсон албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай дүгнэлт, байгууллагын эзэмшиж буй оюуны өмчийн | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эрхийн жагсаалтуудыг шинэчлэлийг хийж байна.<br>Авлигын эсрэг хууль тогтоомж сурталчилсан видео шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим номыг аймаг, сумдын албан ёсны цахим хуудас, төв талбайн лед дэлгэцээр дамжуулан нийтэд хүргэн ажилласан. | |
| **6. ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ** | | | | | | | | | | |
| 123 | 6.1. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах бодлого хэрэгжүүлнэ. | 6.1.1. Ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө | -Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ /га/ | 2020 онд аймгийн хэмжээнд 187.03 га талбайд техникийн, 88.45 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. | Эвдрэлд орсон талбайн хэмжээ багасч, нөхөн сэргээсэн талбайн хэмжээ нэмэгдсэн байна | | Аймгийн Засаг даргын А/12 тоот захирамжаар уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, 2022 онд 10 аж ахуйн нэгж 112.46 га талбайд техникийн, 89.74 га талбайд биологийн, 257.4 га талбайд дүйцүүлэн хамгаалахад 1.3 тэрбум төгрөгөөр, 2023 онд 14 аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нийт 38.45 га талбайд техникийн, 49.14 га талбайд 4 аж ахуйн нэгж, байгууллага түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан карьерын техникийн нөхөн сэргээлт, 31.2 га талбайд биологийн, 1674.2 га талбайд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд техникийн | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн нь өмнөх оныхоос 1333,39 га-аар нэмэгдсэн. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 373.3 мянган ширхэг мод, бут тарьж, арчлан ургуулж, Баянгол сумын Хараа багийн нутагт Бортолгой хэмээх газарт 45.6 га талбайд зурвас байгуулж, Доргонтод 7000 га орчим талбайд бэлчээрийн менежментийг сайжруулж, Ерөө сумын Хужиртын эх нэртэй булгийг хашиж хамгаалж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэн ажиллалаа. | |
| 124 | | 6.1.2. Уул уурхайн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг сайжруулж, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө | -Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ хийгдсэн талбайн хэмжээ, га | Баянгол суманд Бороогоулд ХХК жил 11.5 га талбайд дүйцүүлэн хамгаалах ажил хийсэн. | Дүйцүүлэн хамгаалалтаар бодитой ажлууд хийгдсэн байна | | 2022 онд 10 аж ахуйн нэгж 112.45 га талбайд техникийн, 89.74 га талбайд биологийн, 257.4 га талбайд дүйцүүлэн хамгаалж, 1.3 тэрбум төгрөгөөр эвдэрч олон жил эзэнгүй орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг дарга, "Оюу толгой" ХХК хамтран ажиллах гэрээний дагуу Ерөө сумын "Ялбагийн гол" нэртэй газарт олон жил эзэнгүй орхигдсон 110 га талбайд "Бугант нандин" ХХК, "Үзэгт дэлгэрэх" ХХК-иуд 2023 онд Ерөө сумын Их Өлөнтийн ам нэртэй газар “Сонортрейд” ХХК 3 га талбайд, "Цемент Шохой" ХХК 6 га талбайд, “Ди Зэт энд Ай” ХХК 4 га талбайд, “Бэрлэг майнинг” ХХК 3 га талбайд, “Тод-Ундрага” ХХК 5 | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | га талбайд, “Чамин алт” ХХК 3 га талбайд, Хүдэр сумын Амж нэртэй газар “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК 5.4 га талбайд нийт 29.4 га талбайд техникийн, Ерөө сумын Толгойтын гол нэртэй газарт “Болдтөмөр Ерөө гол” ХХК 6.3 га талбайд, “Инфинити спейс” ХХК 10 га талбайд ойжуулалт нийт 45.7 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>2023 онд “Оюу толгой” ХХК-ийн санхүүжилтээр Ерөө сумын Ялбагийн хөндий орчмын уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон 398.7 га талбайд, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын санхүүжилтээр Ерөө сумын Харганат, Могойн гол, Цамхаг, Өвөрзалаат, Гозонгийн ам, Угтаал гол зэрэг газруудад 1229.8 га талбай буюу нийт 1677.2 га талбайд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалж, энэ онд 1217,6 га-аар нэмэгдүүлж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 29.58 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. | |
| 125 | | 6.1.3. Хариуцлагатай тогтвортой уул уурхайг дэмжиж, хамтран | 2021 - 2025 | хувийн хэвшлийн хөрөнгө | -“Сэлэнгэ баялаг сан” байгуулсан эсэх | - | “Сэлэнгэ баялаг сан” –ийн үйл ажиллагаа тогторжиж, иргэд үр | | “Болдтөмөр Ерөө гол”, "Хонгорын орд", "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК “Бороо Гоулд”, "Сентерра гоулд" ХХК-иуд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, 296,2 сая төгрөгийн | 100 |

| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | дамжуулах станцад сүүлийн 2 сарын хугацаанд идэвхтэй /active/ байгаа урьдчилсан төлбөрт 3300 хэрэглэгчдэд “Таны мал хаана байна вэ? Хамгаалъя гэвэл хариулгатай байлга мессежийг илгээж, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллүүдийг өгч, ”Малчин лавлах-109” дугаарыг олон нийтэд сурталчлах тухай 16 төрлийн постер, зурагт хуудас 900 ширхэг гарын авлага 20 ширхгийг хэвлэн малчдад тараасан.<br>Шаамар, Зүүнбүрэн, Хушаат, Цагааннуур, Түшиг сумдын малчдын төлөөллийг оролцуулан Зүүнбүрэн суманд “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, малчдад мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал сэдвээр танилцуулга хүргэж, малчдын санал хүсэлтийг хүлээн авч, малчдын сайн дурын бүлэг, нөхөрлөл байгуулах талаар зөвлөгөө өгч ажиллаа.<br>Аймгийн хэмжээнд мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг газруудад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж гарал үүслийн гэрчилгээтэй нь тулгалт хийж, Сүхбаатар, Мандал суманд “Өвлийн идэш 2023” арга хэмжээг зохион байгуулж, малчдын гар дээрээс борлуулж | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | буй махны гарал үүсэлд тулгалт хийсэн.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай мэдээ, мэдээлэл агуулсан 600 ширхэг зурагт хуудас, 200 ширхэг сэрэмжлүүлгийг тарааж, малчдыг өмч хөрөнгөө хамгаалах, сонор, сэрэмжийг дээшлүүлэх сэрэмжлүүлэх нийтлэлүүдийг цахим сүлжээнд байршуулж, үйл ажиллагаанд 2.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.<br>Мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх зорилгоор мэдээ мэдээлэл цуглуулж холбогдох шалгалтын ажиллагаа явуулж 15.2 сая төгрөгийн хохиролтой 6 холбогдогчтой 9 хэргийг илрүүлж эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, мал хулгайлах гэмт хэрэг 28 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 23 хэргээр буюу 45.1 хувиар буурсан байна. | |
| 154 | | 7.4.5. Хууль хяналтын байгууллагууд ын ажиллах орчин нөхцөлийг сайжруулан, хүний нөөцийг чадавхжуулж, салбар дундын хамтын ажиллагааг | 2021 - 2025 | Улс, орон нутгийн төсөв | хэрэгжүүлсэн ажлын тоо | Ажлын уялдаа холбоо сайжирч, хамтарсан уулзалтууд ыг зохион байгуулж хэвшсэн. | 1 | | 2021 онд Шүүхийн шинжилгээний албанд томилогдон ирсэн алба хаагчдыг төвийн дулаан, цэвэр бохирт холбогдсон байранд 11 алба хаагчтай түрээсийн гэрээ байгуулан, тав тухтай амьдрах боломжоор хангасан.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 200.0 сая төгрөгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн лабораторийн 170м$^2$ талбайтай 6 ажлын өрөө, автомашины граж | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинэ түвшинд гаргана. | | | | | | | бүхий барилгыг “Сэлэнгэ таван хан” ХХК-иар гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Мөн түр хамгаалах байрыг орон нутгийн 105.0 сая төгрөгийн төсвөөр дээвэр, сангийн ажлыг засварлан сайжруулсан. Хилийн ангийн үлээвэр хөгжмийн зэмсэг шинэчлэхэд шаардагдах 59.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж, шинэ техник хэрэгслээр ханган ажиллалаа.<br>2023 онд 18 хууль хяналтын байгууллагуудын алба хаагчид 8.8 сая төгрөгийн мөнгөн тусламжийг үзүүлж, 350,0 сая төгрөгөөр аймгийн цагдаагийн газрын барилгын гадна фасадны засвар, 48,0 сая төгрөгөөр Ерөө сум болон Бугант тосгоны цагдаагийн хэсгийн байрны засварын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн хийсэн.<br>Алтанбулаг, Түшиг, Жавхлант, Шаамар сумын Дулаанхаан тосгоний цагдаагийн хэсэгт тээврийн хэрэгсэл, торгуулийн багаж, согтуурал хэмжигч багаж, иж бүрэн компьютероор ханган ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан.<br>БНХАУ-ын Өөртөө Засах Орны Цагдаагийн коллежтой хамтран зохион байгуулсан “Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн эмх замбараагүй байдлын үед | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 155 | | | | | | | | | удирдлага зохион байгуулалтаар хангах нь сургалт”-нд 1 алба хаагч, "Хар тамхитай тэмцэх сургалт”-нд 2 алба хаагчийг 14 хоногийн хугацаатай хамруулсан. | |
| 155 | | 7.4.6. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулна. | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | Гэмт хэрэг, зөрчлийн тоо | “Цахим хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсан | Цахим гэмт хэргийн гаралт буурсан байна. | | “Цахим хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг Аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж, цахим сүлжээнд холбогдох хууль, дүрэм, журмыг баримтлан, интернэт орчинд зөв, соёлтой хэрэглээг нийтэд дэлгэрүүлэх, хэвшүүлэх чиглэлээр 12 аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэл хүргүүлсэн. цахим орчинд үйлдэгдэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цахим орчинд үйл ажиллагаа явуулж буй зарын бүлгэмүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, бусдын нэрийг ашиглаж олон нийт хандаж болохуйц цахим зар, мэдээллийн бүлгэм байгуулсан админ болон модератер эрхтэй иргэдийг олж тогтоон бүртгэл судалгаанд авч, хүчирхийллийг өөгшүүлсэн, хүчирхийлэл аллага, хядлага, бага насны хүүхдийг садар самуунд уруу татсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг, зурган постер зэргийг байршуулахгүй, сөрөг мэдээ, мэдээлэл байршуулсан тохиолдолд тухай бүр устган, хууль хяналтын | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байгууллагатай мэдээ, мэдээлэл солилцож хамтран ажиллах чиглэлээр санамж, зөвлөмж өгч ажилласан. Залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сэлэнгэ” цахим телевиз, видео бичлэг, контент, постерыг 67258 дагагчтай хаягт түгээж, аж ахуйн нэгж, байгууллага, ерөнхий боловсролын сургууль, арилжааны банк, иргэд олноор үйлчлүүлдэг аж ахуйн нэгжүүдэд сургалт хийж, мэдээллийн самбарт “Залилах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 25 сэрэмжлүүлэх хуудсыг байршуулсан. Аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар хамтран ерөнхий боловсролын 35 сургуулийн дунд, ахлах ангийн 4562 сурагчдад “Цахим орчинд аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ танхимын сургалт”-ыг улирал бүр зохион байгуулж байна.<br>Цахим гэмт хэрэг 2022 онд 104, 2023 96 бүртгэгдсэн 8 буюу 7.7 хувиар буурч, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй залилах гэмт хэрэг 77 бүртгэгдсэний 26 хэрэгт мөрдөн байцаалтын хэрэг нээн, илрүүлэлт өмнөх оныхоос 6.2 хувиар өссөн байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 156 | | 7.4.7. Улсын бүртгэлийн хэлтсийг архив, үйлчилгээний байртай болгох асуудлыг судалж, мэдээллийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтыг сайжруулна. | 2021 - 2025 | Авсан арга хэмжээний гүйцэтгэл | Улсын төсөв | ТҮНТ-ийн барилгад 603 мкв талбай олгуулах хүсэлтийг хүргүүлж, дэмжлэг авсан. | Барилгын зураг төслийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх ажлыг хийсэн байна. | | Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д Улсын бүртгэлийн хэлтсийн архив, үйлчилгээний байрыг 603 $м^2$ талбайд байгуулахаар ажиллаж байна. | 50 |
| 157 | | 7.4.8. Иргэний тоон гарын үсэгт суурилсан иргэний үнэмлэхийг бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлнэ. | 2021 - 2025 | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | 12722 иргэнд тоон гарын үсэг олгосон. | Тоон гарын үсгийн олголт хийгдэж дууссан байна. | | Иргэдийн тоон гарын үсгийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хүргэх зорилгоор “Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх 3 сарын хугацаатай аян”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, хамрагдвал зохих 73.8 мянган иргэнээс 27.3 мянган иргэнд тоон гарын үсэг олгосон. | 30 |
| 158 | | 7.4.9. Бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ. | 2021 - 2025 | Төсөл хөтөлбөрөөс | Байршуулсан киоск машины тоо | 2021 онд 1734 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ болон тэмдэгтийн хураамжийн төлбөрийг цахим хэлбэрээр үзүүлсэн, | Иргэд улсын бүртгэлийн зарим үйлчилгээг цахимаар авах нөхцөл бүрдсэн байна. | | Улсын бүртгэлийн 22 төрлийн лавлагаа, 50 төрлийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем www.e-mongolia.mn-д иргэний бүртгэлийн 26 төрлийн үйлчилгээ, 12 төрлийн лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 13 төрлийн үйлчилгээ, 7 төрлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээ, 3 төрлийн лавлагааг тус тус цахимаар | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мандал, Сайхан Сүхбаатар сумдад /3 ширхэг/ киоск машин байршуулсан. | | | үзүүлж, 27 үйлчилгээг шуудан хүргэлтээр үзүүлсэн.<br>Төлбөрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор Мандал, Сайхан сумдад 3, Алтанбулаг суманд 1 киост машиныг байршуулсан. | |
| 159 | | 7.4.10. Төрийн Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын стандартын байртай болно. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Архивын стандартын байртай болсон эсэх | - | Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлиig бүрдүүлсэн архивын стандартын байртай болсон байна. | | Төрийн архивын байрны ТЗЭҮ-ийг “ОСИБ ЗТ” ХХК-тай хамтран боловсруулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны зардлыг тусган, төрийн архивын барилгын ажлыг үе шаттайгаар шийдвэрлэхээр ажиллаж байна. | 30 |
| 160 | | 7.4.11. Төрийн Архивын баримтыг цахимжуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Иж бүрэн цахим хэлбэрт шилжүүлсэн хөмрөг, хадгаламжийн нэгжийн тоо | 13 хөмрөгийн 340 хадгаламжийн нэгж | 12 хөмрөгийн 494 хадгаламжийн нэгж, 72352 хуудас цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, агуулга тодорхойлон Төрийн архивын “Archive eDoc” | | “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Сайхан сумын Засаг даргын Тамгын газар, Хөтөлийн цемент-шохойн комбинат, Батлан хамгаалах туслах нийгэмлэгийн Сэлэнгэ аймгийн зөвлөл, Статистикийн хэлтсийн 4 хөмрөгийн 270 хадгаламжийн нэгжийн 49761 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэн. DVD хуулж нөөц ба ашиглалтын хувь үүсгэсэн. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | системд оруулна. | | Төрийн архивт хадгалагдаж буй 175 хөмрөгийн 35119 хадгаламжийн нэгжээс мэдээлэл лавлагааны ажилд ихээр ашиглагддаг удирдлагын 156 хөмрөгийн 4550 хадгаламжийн нэгж буюу 580588 хуудас баримтыг сонгож, цахимжуулсан.<br>Төрийн архивын нэгдсэн систем www.e-document.gov.mn -ээр Нийгмийн даатгалын газар, “Хөтөлийн цемент шохой” ХХК, Бугант тосгоны Захирагчийн алба, “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ, Цахилгаан сан техник, тоноглол, засвар угсралтын трестийн Сэлэнгэ аймаг дахь 4 дүгээр анги, Мандал сумын Засаг даргын Тамгын газрын 369 хадгаламжийн нэгжийн 9468 хуудас цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.<br>2023 онд 143 хөмрөгийн 4417 хадгаламжийн нэгжийн 501894 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, аймгийн хэмжээнд цахимжуулалт 91 хувьтай байна. | |
| **8. НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ** | | | | | | | | | | |
| 161 | 8.1. Хот суурин газрын дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, ухаалаг технологийн | 8.1.1. Сумдын хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | сумд хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй болсон эсэх | - | Суурьшлын бүсийн зохион байгуулалт сайжирна. | | Аймгийн 17 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 2023-2030 он хүртэлх 7 жилийн дунд хугацаатайгаар Мэргэжлийн байгууллагатай хамтран Мандал, Зүүнбүрэн, Хүдэр, Шаамар, Орхон, Орхонтуул, Сант, Жавхлант, Ерөө сумдын хот | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэл хийнэ. | | | | | | | | байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөн боловсруулж, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. | |
| 162 | | 8.1.2. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга байгууламжийг дахин төлөвлөлтөд оруулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Дахин төлөвлөлтөд орсон барилга байгууламжийн тоо | Сүхбаатар сумын 2, 4, 7-р багийн дулааны станцын ажилчдын орон сууц, 5, 22, 23, 24, 25-р байр, Мандал сумын 1, 2-р багийн 11, 36-р байруудын орон суугчдаас дахин төлөвлөлтөд оруулах санал ирүүлсэн. | Хот, суурин газрын хөгжлийг дэмжих, газрын нөхцөл, нөөц, чадавхид тохирсон инженерийн шийдлээр оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. | | Сүхбаатар сумын 7-р багт байрлалтай балгас барилгыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Баганадант” ХХК буулгаж, аймгийн төв Сүхбаатар сум дахь ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу иргэдийн оролцоотой газрыг дахин төлөвлөх замаар шинээр барих, дахин төлөвлөлтөд оруулж, барилгажуулах, газрыг шинэчлэн зохион байгуулах 7 байршил бүхий хил заагийг тогтоон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 87 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулсан.<br>Сүхбаатар сумын ашиглалтын шаардлага хангахгүй 7 дугаар багийн 8 айлын 2 орон сууцыг дахин төлөлөлтөд оруулж, “Колорс теч” ХХК-тай хамтран 3 блок 325 айлын орон сууц барих ажлыг эхлүүлсэн. | 100 |
| 163 | | 8.1.3. Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн | 20 | Үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, иргэд ая | | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Алтанбулаг сумыг хилийн боомтын цэвэрлэх байгууламжтай холбох бохир ус зайлуулах шугам, | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | | | хувь, нэвтрэх чадвар нэмэгдсэн эсэх | | тухтай зорчих нөхцөл бүрдэнэ. | | орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Нягт холбоос констракшн” ХХК хийж ашиглалтад оруулж, Алтанбулаг боомтын хил, гаалийн байгууллагын 3600$м^2$ талбай бүхий 6 давхар нэг цэгийн үйлчилгээний цогцолбор, ачаа тээврийн хэсэг болон гадна инженерийн шугам сүлжээ, 4 эгнээ 1.7 км урттай хатуу хучилттай хөрсний ус зайлуулах дренаж систем бүхий засмал зам, 7000 $м^2$ талбай бүхий авто зогсоолын зам талбайн ажлыг хийсэн. | |
| 164 | | 8.1.4. Мандал суманд дулааны станц барьж ашиглалтад оруулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв Улсын болон орон нутгийн төсөв | -Ашиглалтад орсон эсэх | - | Иргэд жилийн 4 улиралд халуун усаар хангагдаж, ая тухтай амьдрах нөхцөл бүрдэнэ. | | Мандал суманд 25 мВт-ын дулааны цахилгаан станц 30 га газрын асуудлыг шийдвэрлэн инженер геологийн судалгаа, байрзүйн зураглал, барилгын зураг төсвийн ажлууд хийж байна. | 30 |
| 165 | | 8.1.5. Эрчим хүчний нөөцийг ашиглан эх үүсвэр барих, шугам сүлжээ, ачаалал ихтэй дэд станцуудыг өргөтгөх, шинэчлэх ажлыг үе | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Өргөтгөл, шинэчлэлийн ажлын хувь | Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг боловсруулан ажлыг эхлүүлсэн. | Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагаа дээшилсэн байна. | | Шаамар сумын шинэ суурьшлийн бүсэд орон нутгийн хөгжлийн сангаас 65.0 сая төгрөгийг гарган 10/0.4 кВ-ын дэд станц, 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татах, Сүхбаатар сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах хүчдэлийн уналттай 45 айл өрхийг хангах 1.4 км урттай 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилж, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шаттайгаар шийдвэрлэнэ. | | | | | | Мандал сумын шинэ суурьшлийн бүсэд 6/0.4 кВ-ын 160 кВА хүчин чадалтай дэд станц, 0.4 кВ-ын 560м урт цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажлыг хийж, хүчдэлд залгаж ашиглалтад оруулсан. | |
| 166 | | 8.1.6. Олон улсын болон улс, орон нутгийн авто замын сүлжээнд засвар, шинэчлэлтийн ажлыг хийнэ. | 2021 - 2025 | Замын сангийн хөрөнгө | -Засвар, арчлалтын ажлын хувь | Авто замын ажлыг концессын гэрээгээр эхлүүлсэн. | Автозамын ашиглалт уртсаж, иргэдийн ая тухтай авто замаар зорчих нөхцөл бүрдэнэ. | | Аймгийн төвд 0.6 км 4 эгнээ автозам, Шаамар, Хүдэр, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдыг 120,85 км хатуу хучилттай замаар холбож, 1,5 асфальтобетон хучилттай авто зам, хандиваар 420 м хучилттай авто зам, орон нутгийн хөгжлийн сан, аймаг, сумын хөрөнгө оруулалтаар 9.9 км асфальтбетон хучилттай авто зам, 29,8 км хайрган замын ажлыг хийж, замын ажлыг 31,3 км-ээр нэмэгдүүлсэн. | 100 |
| 167 | | 8.1.7. Насжилт удаашралтай гүүрэн байгууламж, бетон гүүрэнд их засварын ажлыг хийж гүйцэтгэнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Их засварын ажлын хувь | Сүхбаатар сумын үерийн далан засварлах ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, эхлүүлсэн. | Иргэдийн аюулгүй тав тухтай зорчих нөхцөл бүрдсэн байна. | 6,3 тэрбум төгрөг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхонтуул суманд төмөр бетон гүүр барих ажлын эхний ээлжийн гүүрийн байгууламж 70 хувьтай, Алтанбулаг суманд 591,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хяраан голын гүүр барих ажлыг хийж дуусган Сант сумын Ивэн голын үерийн хамгаалалтын барилгын ажил 40 хувьтай хийгдэж байна.<br>Үерийн улмаас эвдэрч гэмтсэн Хараа голын 136 м төмөр бетон, салааны 15м урт гүүрүүдийн засвар шинэчлэлтийн ажлыг | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | “Ангад аривжих”ХХК, “Эрдэнэ суварга” ХХК-иуд хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. | |
| 168 | | 8.1.8. Зарим сумдад инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологи нэвтрүүлж, дулааны тоолуурыг бүрэн суурилуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлсэн хувь -Дулааны тоолуур суурилуулсан тоо | Нийт шугам сүлжээний 90 гаруй хувь нь 25-62 жил болж байна. Сумдын 53 хувь нь усан сангүй, 73 хувь нь цэвэрлэх байгууламж гүй | Дулаан алдагдлыг бууруулж, өртөг зардал хэмнэгдэж, иргэд тав тухтай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. | | Аймгийн төсвийн 878.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандал, Орхон, Сүхбаатар, Алтанбулаг, Түшиг сумдад нийт 1897 м инженерийн шугам сүлжээг шинээр татах ажлыг хийсэн.<br>Сүхбаатар сумын цэвэрлэх байгууламжийн их засвар, шинэчлэлийн ажилд 500 сая төгрөгийг засвар шинэчлэлтийн ажлыг хийж, иргэд тав тухтай орчинд амьдрах нөхцөл бүрдүүлсэн. | 100 |
| 169 | | 8.1.9. Аймгийн төвд орчин үеийн шаардлагад нийцсэн нийтийн тээврийн зогсоол бий болгоно. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Орчин үеийн тохилог нийтийн тээврийн зогсоолтой болсон эсэх | - | Иргэд тав тухтай зорчих боломж бүрдсэн байна. | | Сүхбаатар сумын хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж, аймгийн төвд зоригчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан нийтийн тээврийн буудлыг байгуулахаар тусган хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна | 30 |
| 170 | 8.2. Байгалийн өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт байгаль, түүх, соёлын өвийг түшиглэн | 8.2.1. Байгаль экологийн онцлог, түүх соёлын биет ба биет бус өв, соёлыг хадгалан нутгийн иргэдийг түшиглэсэн | 2021 - 2025 | Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө | -Аймгийн аялал жуулчлалыг бүсчилэн хөгжүүлсэн эсэх | Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль экологийн онцлог, түүх соёлын биет ба биет бус өв соёлыг хадгалсан | Аялал жуулчлалын загвар баазууд бий болж, аялах жуулчдын тоо нэмэгдсэн байна. | | Аялал жуулчлалын хөгжлийн төвтэй хамтран Алтанбулаг сумын нутаг дахь “Гүн нуур”, “Хонд”, “Сайхны хөтөл”, Баруунбүрэн сумын “Амарбаясгалант хийд”, Алтанбулаг, Шаамар сумдын нутгийг хамарсан Тужийн нарсан ойд зэрэг байгалийн өвөрмөц, содон тогтоц, уламжлалт ёс заншил, түүх дурсгалын өлгий | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | аялал жуулчлалыг хөгжүүлж дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | аялал жуулчлалыг /НИТАЖ/ бүсчилэн хөгжүүлнэ. | | | | аялал жуулчлал эрхэлдэг 1 газар байна. | | | нутаг, түүх дурсгалт газруудаар виртуал аялал, аймгийн аялал жуулчлалын салбарын цахим контентийг хийж, иргэд, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд, байгаль, түүх, соёлын өв бүхий газруудыг таниулан сурталчилж ажилласан. “БААТУДС” ХХК-тай хамтран Бэлчирийн бүсийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулсан.<br>Байгаль экологийн онцлог бүхий хаягдал модоор “Бугант нандин” уран сийлбэрийн фестиваль, түүх соёлын биет ба биет бус өв соёлыг хадгалсан “YERUU CUP” мөсны сур, шагайн тэмцээнийг зохион байгуулж, нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль экологийн онцлог, түүх соёлын биет ба биет бус өв соёлыг хадгалсан аялал жуулчлалыг Ерөө, Жавхлант сумдын жуулчдын баазыг түшиглэн зохион байгуулсан. | |
| 171 | | 8.2.2. Аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах цэгүүдийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тохижуулна. | 2021 - 2025 | Хувийн хэвшил, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө | Орчин үеийн шаардлагад нийцсэн Түр буудаллах цэгийн тоо | Шаамар суманд түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах 3 га газрыг шийдвэрлэсэн | Жуулчдын аюулгүй тухтай, аюулгүй зорчих нөхцөл бүрдсэн байна. | | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баруунбүрэн сумын “Амарбаясгалант хийд”-ийн орчим отоглох цэг байгуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран Шаамар сумын “Ээж мод”-ыг шашин мөргөлийн төв болгон хөгжүүлэх, шинээр отоглох цэг байгуулах байгуулахаар зураг төсвийг боловсруулан Байгаль | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. | |
| 172 | | 8.2.3. ”Сэлэнгэ аймгийн аялал жуучлалын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | 2021 - 2025 | Орон нутгийн төсвийн хөрөнгө | -Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Хөтөлбөрийн 1 шатны хэрэгжилт 81 хувьтай байна. | Аялал жуулчлалын салбар тогтвортой хөгжсөн байна. | | “Сэлэнгэ аймгийн аялал жуучлалын хөтөлбөр”-ийн 5 бүлгийн 36 зорилттойгоор боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>“Ханш нээх”, “Гонгорын бумбаны тахилга”, “Цам харайх”, “Майдар эргэх”, Мандал сумын Түнхэл тосгонд “Монос цэцэглэх үеэр” Хараагийн баяр”, "Аймгийн аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн уулзалт“, "Аялал жуулчлалын салбарт виртуал аялал жуулчлалыг хэрхэн хөгжүүлэх, түүнд зориулсан өгөгдлийн сан, программ хангамж платформ бий болгох цахим сургалт”-ыг зохион байгуулж, 60 метрийн урттай, 10 метрийн өндөртэй, нэг чигийн урсгалтай нэг хүний замтай "Дүүжин гүүр", экстрим аяллын үйлчилгээ, байгаль экологийн онцлог бүхий хаягдал модоор “Бугант нандин” уран сийлбэрийн фестиваль, түүх соёлын биет ба биет бус өв соёлыг хадгалсан “YERUU CUP” мөсны сур, шагайн тэмцээний зэрэг аялал жуулчлалын шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнээр нэмэгдүүлсэн.<br>Ардын хувьсгалын түүхэн дурсгалт газар “Сэлэмт хөшөө”, “Дөрвөлжин сүмийн туурийн хөшөө”, | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | “Бүрээчийн хөшөө”, “Д.Сүхбаатар хөшөө”-г сэргээн тохижуулах ажилд 100,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Аялал жуулчлалын гол бүс нутаг Сүхбаатар сумын ногоон байгууламж, Сүхбаатар хаалга, Шаамар сумын Ээж мод, Алтанбулаг сумын “Хоёр элс” орчимд 4 модон жорлон байрлуулж, аялал жуулчлалын бүс нутагт дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэсэн.<br>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баруунбүрэн сумын “Амарбаясгалант хийд”-ийн орчим отоглох цэг байгуулсан. | |
| 173 | | 8.2.4. Аймгийн аялал жуулчлалын маршрут, амралтын газруудын байршлыг харуулсан аппликейшныг мэргэжлийн байгууллагууд тай хамтран хийж нэвтрүүлнэ. | 2021 - 2025 | Төсөл хөтөлбө рийн хөрөнгө | -Маршрут, аппликейшинт эй болсон эсэх | Аялал жуулчлалын маршрут, амралтын газруудын байршлыг харуулсан аппликейшн ыг хийж нэвтрүүлэх ажлыг шинээр хийхээр төлөвлөсөн. | Аялагчдын тоо нэмэгдэж, аялал жуулчлал эрхлэгчдийн ашиг орлого нэмэгдэж, үйл ажиллагаа өргөжинө. | | | Аймгийн байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар, аяллын маршрут зэрэг 23 төрлийн мэдээлэл агуулсан “Сэлэнгэ аялал” гар утасны аппликейшны мэдээ, мэдээллийг шинэчлэх, хөгжүүлэх ажлыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулж, дотоод, гадаадын 613.3 мянган жуулчид манай аймгийг зорин ирсэн нь өмнөх оныхоос 20 хувиар нэмэгдсэн. | 100 |
| 174 | 8.3. Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон | 8.3.1. “АТАР IV” аяныг өрнүүлэн, тариалангийн салбарын | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсвийн | -Шинэ техник, технологи нэвтрүүлсэн байдал. -Мэргэжлийн | 2021 онд улаанбуудай 130.8 мянган га талбайгаас | Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой хөгжинэ. | | | Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний 5 жилийн төлөвлөгөөний төслийг | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цогц, ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ. | бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, Сэлэнгэ аймгийн газар тариалангийн бодлогыг боловсруулна. | | хөрөнгө, төсөл хөтөлбөр | боловсон хүчний тоо - Үрийн шинэчлэлт - Усалгаатай талбайн хэмжээ | 189.0 мянган тн, арвай 2.6 мянган га талбайгаас 3.4 тн, овьёос 3.9 мянган га талбайгаас 4.7 мянган тн, гурвалжин будаа 501 га талбайгаас 340 тн, тэжээлийн ургамал 18.0 мянган га талбайгаас 30.5 мянган тн, тосны ургамал 42.5 мянган га талбайгаас 32.5 мянган тн, төмс 2.1 мянган га талбайгаас 23.0 мянган тн, хүнсний ногоо 2.7 мянган га талбайгаас 33.4 мянган | | | боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд бүрэн ашиглагдаж буй 30 аж ахуйн нэгжийн 15000 га талбай услах хүчин чадалтай услалтын систем байна.<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Сант суманд 240 га талбайн хуучин Ивэн голын услалтын системийг шинэчлэх ажил 80 хувьтай хийгдэж байна.<br>Нэгж га талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн корпорациас 7545 кг бордоог хөнгөлөлттэй нөхцлөөр аж ахуйн нэгж, иргэдэд олгосон.<br>2023 онд манай аймаг нэгж га талбайгаас 15.5 цн үр тариа, 127.9 цн төмс, 172.4 цн хүнсний ногоо хураан авч үр тарианы ургац өмнөх оноос 9.6, төмс 3.1, хүнсний ногоо 24.7 хувиар өссөн байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тн ургац тус тус хураан авсан. | | | | |
| 175 | | 8.3.2. Газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалан ойн зурвас, хашаажуулах төслийг хэрэгжүүлэн эрдэм шинжилгээний байгууллагууд, төр хувийн хэвшлийн оролцоотойгоо р ирээдүйтэй болон нутагшсан үрийн хангамжийг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт | Техникийн шинэчлэлт, хөрсний үржил шимийн үзүүлэлт | - | Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой хөгжинэ. | | Орхон, Жавхлант, Сайхан, Сант сумдад 449.9 га талбайд шинээр услалтын систем ашиглалтад орж, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сант суманд Ивэн голын 240 га талбайг услах хүчин чадалтай, услалтын системийн байгууламж барих ажил 60 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.<br>2021 онд 25 км ойн зурвас, 3.7 мянган га талбайг хашаажуулж, 2022 онд 159 га талбайд 29.9 км ойн зурвас байгуулж, Шаамар, Хүдэр, Орхон сумдын 4.6 мянган га талбайг хашаажуулж, 2023 онд улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 115.1 мян.га талбайг хашаажуулж, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Орхон, Сайхан, Хүдэр, Хушаат сумдын 8 аж ахуйн нэгж 645 га талбайд агро-ойжуулалт хийсэн байна.<br>2023 онд 59.3 мянган тн бордоог газар тариалангийн үйлдвэрлэлд хэрэглэсэн. Хушаат сумын "Элит үр" ХХК-тай хамтран “Сэлэнгэ-5” сортын төмсний үрийг үржүүлэх зорилгоор Ерөө, Сүхбаатар, Хүдэр, Орхон, Хушаат, Сант, Баруунбүрэн сумдын 21 иргэнд 50 тн үрийн төмсийг олгосон. "Хүнсний ногоо" хөтөлбөрийн | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хүрээнд Улсын төсвийн 136.7 сая төгрөгийн үнэ бүхий 7.5 тн хүнсний ногооны үрийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр 17 суманд олгож, 2.1 мянган га талбайгаас 27.0 мянган тн төмс, 3.6 мянган га талбайгаас 47.1 мянган тн хүнсний ногоог хураан авсан. | |
| 176 | | 8.3.3. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин, хүлэмжийн болон зоорийн аж ахуйг хөгжүүлж, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, иргэд, аж ахуйн нэгжийн хөрөнгө | -Хүлэмжийн аж ахуйн талбай, зоорины тоо, багтаамж | - | Төмс, хүнсний ногооны нийлүүлэлт нэмэгдэж, хадгалалт уртасна | 490,0 | “Шинэ хөдөө” төслийг хэрэгжүүлж, Баруунбүрэн суманд 11 га талбайд 384 м2 бүхий 4 улирлын хүлэмж, 120 м2 бүхий 3 ширхэг зуны хүлэмж, 1000 ширхэг жимс жимсгэнийн мод, 50 м гүний худаг, дуслын болон мананжуулах усалтын систем, цахилгаан хангамж бүхий өвөл, зуны хүлэмжийн цогцолборыг 490.0 сая төгрөгөөр ашиглалтад оруулсан.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Алтанбулаг, Цагааннуур, Орхон, Ерөө, Сүхбаатар сумдад тус бүр 10*6 хэмжээтэй 35 ширхэг нийлэг хальсан хүлэмж, 10 тн багтаамжтай усны сав бүхий 3 ширхэг хүлэмжийн цогцолбор, Шаамар суманд 20*6 хэмжээтэй 30 ширхэг нийлэг хальсан хүлэмж, 10 тн багтаамжтай усны сав 3 ширхэг, 1400 ширхэг жимсний суулгац бүхий цогцолбор аж ахуй байгуулсан. Шаамар сум орон нутгийн хөгжлийн сан, Дэлхийн зөнгийн санхүүжилтээр 20*6 хэмжээтэй 52 ширхэг зуны хүлэмж, | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 348 $м^2$ өвлийн, 20.3 мянган $м^2$ зуны хүлэмж шинээр барьж, ашиглалтад оруулсан байна.<br>Мандал суманд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 200 тн зоорийг барьж ашиглалтад оруулсан. | |
| 177 | | 8.3.4. Бордооны хангамжийг нэмэгдүүлж, тариалах талбайн 80 хувьд бордоотой тариалалт эрхэлж га-аас авах ургацын хэмжээг тогтворжуулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, төсөл хөтөлбөр | -Нэгж га талбайгаас хураан авах ургацын хэмжээ. | - | Нэг га талбайгаас хураан авах ургацын хэмжээ нэмэгдэнэ. | | 2022 онд гуматын бордоо 30.7 мянган тн, бусад бордоо 28.6 мянган тн, 2023 онд азотын бордоо 50.0 мянган литр, нийлмэл бордоо 2.1 мянган тн, гуматын бордоо 29.7 мянган тн буюу идэвхижүүлэгч бодисыг 250 тариаланчид хэрэглэж, дунджаар 57.0 мянган тн бордоо хэрэглэсэн өмнөх оныхоос 5-6 хувиар нэмэгдсэн. | 100 |
| 178 | | 8.3.5. Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулж, малчид, тариаланчдыг эрсдэлээс хамгаална. | 2021 - 2025 | Үйл ажиллагааны зардлаар | -Даатгалд хамрагдсан иргэн аж ахуйн нэгжийн тоо | - | Тариаланчдын 50 хувийг даатгалд хамруулж, тариаланчдын үйлдвэрлэл тогтвортой болно. | | Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, малчдыг эрсдлээс хамгаалах зорилгоор “Төрийн банк”-тай хамтран “Малын индексжүүлсэн даатгал”-ыг орон нутгийн малчдад сурталчлан, аймгийн хэмжээнд 411 малчин өрх, 4 аж ахуй нэгж байгууллага малыг индексжүүлсэн даатгалд, 178 малчин өрх, 1 аж ахуй нэгж байгууллага бусад төрлийн даатгалд малаа даатгуулж, нийт малчин өрхийн 48,5 хув даатгалд хамруулсан. | 90 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 179 | | 8.3.6. “Монгол мал-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, малын чанар, ашиг шимийг сайжруулна. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв | -Цэвэр эрлийз малын тоо | - | Хагас суурин мал аж ахуй эрхлэгч өрх, аж ахуй нэгж нэмэгдэнэ. | | “Монгол мал-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран сүү, махны чиглэлийн үхрийн тоо толгой, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор 17 сумын 2200 үхэр сүрэгт мах, сүүний чиглэлийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, Сант, Орхон, Ерөө, Шаамар, Мандал, Жавхлант сумдад бод малын хээлтүүлэгч мал худалдан авахаар нээлттэй болон шууд худалдан авалтын тендерийг зарлан хээлтүүлэгч худалдан авч малчид болон мал үржүүлэг технологийн нэгжид гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн.<br>3 сумын 600 толгой бог малд шингэлсэн үрээр зохиомол хээлтүүлэг хийгдсэн.<br>2023 онд 4.3 мянган толгой адуу, 13.5 мянган толгой үхэр, 66.2 мянган толгой хонь, 28.2 мянган толгой ямаа нийт 112.6 мянган толгой мал, 4.9 мянган тн махыг зах зээлд нийлүүлсэн. Цаашид мал сүргийн тоог бууруулах, сумдад мал сүрэгт хийх технологит үзлэг ангилалт заазлалтыг чанартай зохион байгуулж үржилд тэнцэхгүй мал, эр сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, мал мах бэлтгэлийг нэмэгдүүлэх чиглэлийг сумдад хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Аймгийн нийт мал сүргийн 21.8 хувь нь нутгийн шилмэл үүлдэр омгийн мал, 4.2 хувь нь гадаад орноос цэврээр оруулж ирсэн мал сүргийн 1, 2 дугаар үеийн эрлийз мал эзэлж, цэвэр эрлийз малын тоо өмнөх оныхоос 6.1 хувь буюу 25.8 мянган толгойгоор өссөн байна.<br>Аймгийн хэмжээнд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 595 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулсан нь өмнөх оныхоос 11,9 хувиар өссөн. | |
| 180 | | 8.3.7. Мал эмнэлэгийн ариутгал, халдваргүйтгэл, хяналт шалгалтын нэгдсэн цэгийг Тахилт, Хөшөөтийн даваанд байгуулна. | 2021 - 2025 | Аймаг, сумын төсөв | -Хяналт шалгалтын цэгийн тоо. | - | Халдварт өвчний тархалт буурч, мал аж ахуйн шилжилт хөдөлгөөнд тавигдах хяналт сайжирна. | | ”Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйтгэл, хяналт шалгалтын нэгдсэн цэг”-ийг Тахилт, Хөшөөтийн даваанд байгуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. | 30 |
| 181 | | 8.3.8.Мал, амьтны гарал үүслийн гэрчилгээ, баталгаажуулалтын нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, гадаад, дотоод худалдааны | 2021 - 2025 | Орон нутгийн төсөв | -Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийг цахим системд оруулсан хувь | Аймгийн хэмжээнд 2022 онд бүх сумдад мал эмнэлгийн цахим систем бүрэн нэвтэрч, ажил, арга | МАА-н гаралтай бүтээгдэхүүний гадаад болон дотоод худалдаа нэмэгдэнэ. | | Мал, амьтны гарал үүслийн гэрчилгээ, баталгаажуулалтын нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, аймгийн хэмжээнд 27.5 мянган гэрчилгээгээр 7.4 мянган толгой адуу, 17.3 мянган толгой үхэр, 12 тэмээ, 79.0 мянган толгой хонь, 37.1 мянган толгой ямаа, 356 гахай, 8 тахиа, 1 нохой буюу нийт 141.3 мянган (*хүнсэнд 112.7 мянган толгой, өөр аймаг* | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | чөлөөт байдлыг хангана. | | | | хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл 95-аас дээш хувьтай орсон. | | | *сумруу явсан 4.6 мянган толгой, өөр аймаг, сумаас ирсэн 22.7 мянган толгой, аймаг сум дотроо 1.2 мянган*) толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийсэн.<br>Мал эмнэлгийн 16.4 мянган цахим гэрчилгээгээр 4.9 сая кг мах, махан бүтээгдэхүүн, 61.4 мянган кг дайвар бүтээгдэхүүн, 11.3 сая литр сүү сүүн бүтээгдэхүүн, 4.9 мянган кг зөгийн бал, 11.2 мянган ширхэг өндөг, 35.3 мянган кг ноос ноолуур, 11.7 мянган ширхэг арьс шир бүтээгдэхүүнд үзлэг хийж, хүнсний аюулгүй байдлыг хянан баталгаажуулсан. | |
| 182 | 8.3. Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон цогц, ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ. | 8.3.9.Жимс, жимсгэнэ хөтөлбөрийг хэрэгжүүлэн тариалах талбайн хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлж боловсруулах цехтэй болно. | 2021 - 2025 | Улсын болон орон нутгийн төсөв, аж ахуй нэгжийн хөрөнгө | -Талбайн хэмжээ, нэр төрлийн тоо - Шинээр бий болсон цехийн тоо | - | Тариалах талбайн хэмжээ нэмэгдэж жимс, жимсгэнэ боловсруулах цехтэй болсон байна | | 2023 онд жимс, жимсгэнийн тариалан эрхэлдэг 497 иргэн 9 аж ахуй нэгж 825 га талбайд тариалалт хийж, 303,4 тн жимс үйлдвэрлэж, шинээр 2 га талбайд чацаргана, үхрийн нүд, алим, чавга, абрикос, бэсрэг алим, чангаанз болон бусад жимс, жимсгэнэ нийт 45.3 мянган ширхэг суулгацыг ил талбайд болон хүлэмжинд бойжуулан зах зээлд нийлүүлсэн жимс жимсгэний тариалсан талбайн хэмжээ өмнөх оныхоос 6.6 хувиар нэмэгдсэн.<br>Жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад улсаас 10.0 мянга орчим жимсний суулгацыг орон нутгийн иргэдэд хямдралтай үнээр нийлүүлж, | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Баруунбүрэн, Шаамар сумдад ашиглалтад орсон хүлэмжийн цогцолборт 2400 ширхэг чацаргана, үхрийн нүд, монос, алим тарьж, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Орхон, Хүдэр сумдын 5 аж ахуй нийт 245 га талбайд агро-ойжуулалт хийсэн байна.<br>Хоршоо хөгжүүлэх сангаас Сант сумын 1 иргэнд жимс жимсгэнийг хатааж эцсийн бүтээгдэхүүн боловсруулах савлах үйлдвэрийг байгуулахад 24 сая төгрөгийн зээлийг олгож, үйл ажиллагааг нь дэмжсэн. | |

…………………………..oOo……………………

## "СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

| № | Агуулга | Нийт зорилтын тоо | Үүнээс | | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 хувь | 90 хувь | 70 хувь | 50 хувь | 30 хувь | Хэрэгжээгүй | |
| 1 | "Үндэсний нэгдмэл үнэт зүйл" бүлэг | 11 | 10 | 1 | - | - | - | - | 99.09 |
| 2 | "Хүний хөгжил" бүлэг | 46 | 40 | 1 | 4 | 1 | - | - | 96.08 |
| 3 | "Амьдралын чанар ба дундаж давхарга" бүлэг | 27 | 26 | - | 1 | - | - | - | 98.88 |
| 4 | "Эдийн засаг" бүлэг | 16 | 11 | - | 2 | 1 | 1 | - | 82.5 |
| 5 | "Засаглал" бүлэг" | 22 | 19 | 2 | 1 | - | - | - | 97.72 |
| 6 | "Ногоон хөгжил" бүлэг | 15 | 15 | - | - | - | - | - | 100 |
| 7 | "Амар тайван, аюулгүй нийгэм" бүлэг | 23 | 20 | - | 1 | 1 | 1 | - | 93.47 |
| 8 | "Бүс, орон нутгийн хөгжил" бүлэг | 22 | 19 | - | 1 | - | 2 | - | 92.27 |
| **Нийт** | | **182** | **141** | **4** | **10** | **3** | **4** | **0** | **95.77** |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**